# ХУУЛЬ, ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ

2025.12.20 Таргт сум

| № | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | № | Агуулга | Хэрэгжилтийн явц | Өөрийн үнэлгээ | Дээд шатны үнэлгээ | Үнэлгээний тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Монгол Улсын хууль** | | | | | | | |
| **Улсын Их Хурлын тогтоол** | | | | | | | |
| 1 | Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2016-04-14<br>Дугаар 2016/34 | 1 | 7. газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөлтийг боловсронгуй болгох, бэлэн байдлыг хангах, гамшгийн аюулыг эрт зарлан мэдээлэх тогтолцоог өргөтгөх, улсын болон байгууллага, аж ахуйн нэгжийн нөөцийн удирдлага, чадавхыг бэхжүүлэх, урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэл, иргэд, олон нийтийн байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх; | Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг жил бүр шинэчлэн боловсруулж ажиллаж байна. Гамшгийн эрсдэлээс урьчилан сэргийлэх чиглэлээр Онцгой байдлын газраас зохион байгуулсан цахим сургалтуудад тогтмол албан хаагчдаа оролцуулж мэдээлэлтэй болсон. Мөн Уганбаяр генералын сургалтанд хамрагдаж нөхцөл байдлын үнэлгээ хийж ажиллах мэдээлэлтэй болсон. Энэ оны байдлаар цас ихтэй газруудад зам харгуй гаргах, эрсдэлтэй айл өрхүүдэд эрүүл мэндийн үйлчилгээг тухай бүр үзүүлж байх талаар ирэх оны төсөвт зардлыг төлөвлөн ажиллахаар зориод байна. | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | |
| | | 3 | 8. “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө”-г батлан, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний зардлыг жил бүрийн улсын төсөвт тусган шийдвэрлүүлж байх. | Засаг даргын нөөц хөрөнгө дээр 10,0 төгрөг төсөвлөсөн. | Хэрэгжсэн | | |
| 2 | АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ<br>2023-06-30<br>Дугаар 2023_59 | 1 | 3. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагааг улсын болон аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар ханган хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Авлигатай тэмцэх газар /З.Дашдаваа/-т тус тус үүрэг болгосугай. | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн суманд хамаарах заалтуудыг авч төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Иргэд Авлигатай тэмцэх газарт хандах талаар мэдлэгтэй болсон. Төрийн байгууллагын удирдлагууд хуулийн хэрэгжилтийг сайжруулж албан хаагч томилохдоо Авлигатай тэмцэх газраар хянуулж зөвшөөрөл авч хэвшсэн. Төсөл хөтөлбөр, худалдан авах ажиллагааны ажлын хэсэгт ажиллаж байгаа албан хаагчид шаардлагатай үед мэдэгдэл тайлбарыг өгөх мэдээлэлтэй болсон. Энэ оны байдлаар зөрчил гараагүй. | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | |
| 3 | МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ<br>2023-11-10<br>Дугаар 2023_93 | 2 | 1.10. төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих, ашиглалтад хүлээн авах, өмчид хүлээн авах үйл ажиллагаанд ногоон байгууламжийн стандарт болон тусгай хэрэгцээт иргэдийн хэрэгцээнд нийцсэн стандартыг чанд мөрдөж хэрэгжүүлэх, зохион байгуулах; | 2025 онд иргэд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих, ашиглалтад хүлээн авах, өмчид хүлээн авах үйл ажиллагаанд ногоон байгууламжийн стандарт болон тусгай хэрэгцээт иргэдийн хэрэгцээнд нийцсэн стандартыг чанд мөрдөн ажиллаж байна. | Хэрэгжсэн | | |
| 4 | Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай<br>2024-01-12<br>Дугаар 2024_05 | 1 | 1.6. төрийн цахим үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд операторын горимоор хүргэх цэгийг аймаг, сум, нийслэл, дүүрэг, хороонд байгуулах. | Операторын үйлчилгээ үзүүлэх цэгтэй болсон.Жилд 500 орчим иргэ үйлчлүүлж байна. | Хэрэгжсэн | | |
| 5 | Засгийн газарт чиглэл өгөх тухай<br>2024-01-17<br>Дугаар 2024_11 | 1 | 1.2. төрөөс үзүүлж байгаа үйлчилгээний төлбөр, хураамж болон тэдгээрийн зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх, хууль тогтоомж зөрчсөн төлбөр, хураамжийг хүчингүй болгох арга хэмжээ авах. | 2025 онд хууль тогтоомж зөрчсөн хураамж байхгүй. | Хэрэгжсэн | | |
| 6 | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай<br>2024-04-18<br>Дугаар 2024_27 | 1 | 2. 2.Хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагаа, арга хэмжээг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7, 6.8, 6.9 дэх хэсэгт заасны дагуу үндсэн чиглэл, хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Ёс зүйн хороо, Засгийн газрын, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороо, бүх шатны томилох эрх бүхий албан тушаалтанд тус тус даалгасугай. | Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд 16 төрийн албан хаагчийг түрээсгүй амьдрах байраар хангасан. ЭМТ-ийн боловсон хүчин дутагдалтай байсан учраас ЭМШУИС төгссөн залуу эмчийг сумандаа урьж ажиллуулан жилийн 6,0 сая төгрөгийн урамшуулал олгохоор, дулаан гэр орноор хангахаар гэрээ байгуулан ажиллуулж байна. ЗДТГ-ын 22, Засаг даргын эрхлэх хүрээний босоо удирдлагатай 8 албан хаагчид сар бүр 40 хүртэл хувийн орон нутгийн нэмэгдэл олгосон. ЗДТГ-ын | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | тавилга, техник хэрэгслийг бүрэн шинэчилсэн. Албан хаагчид ажиллахад тав тухтай орчинг бүрдүүлсэн. | | | |
| 7 | Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай<br>2024-05-02<br>Дугаар 2024_37 | 1 | 2.а. а/бүх шатны боловсролын сургалтын байгууллага, дотуур байрны гадаад болон дотоод орчны аюулгүй байдлын стандартыг хангуулах, боловсролын байгууллагын барилга, өргөтгөлийн ажилд төр, иргэний хамтарсан хөндлөнгийн хараат бус хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх; | Сургуулийн дотуур байрны үйл ажиллагаанд 1 удаа шалгалт хийсэн. Хүүхэд амьдрах орчин болон камерын хяналт сайн байсан. | Хэрэгжсэн | | |
| | | 2 | 2.б. б/хөгжлийн бэрхшээлтэй сурагчийн эрхийг хангах хүрээнд тэднийг дэмжих төв ажиллуулж, тохирох орчныг бүрдүүлэх, тусгай сургалтын хэрэглэгдэхүүн бий болгох, эцэг, эхийн оролцоог хангаж, багшийн туслахаар ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх, багш, багшийн туслах, ажилтанд нэмэгдэл хөлс олгох хуулиар тогтоосон арга хэрэгслийг үр дүнтэй хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын цогц арга хэмжээ авах; | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй хэрхэн ажиллах талаар аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн хамгааллын салбар зөвлөлөөс ирж сургалт зохион байгуулсан. | Хэрэгжсэн | | |
| | | 3 | 3.в. в/аймаг, дүүрэг бүрд байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд зориулсан нөхөн сэргээх, нийгэмшүүлэх, боловсрол олгох, өдөр өнжүүлэх хөгжлийн төв болон байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн төрөлжсөн асрамж халамжийн төв байгуулах, холбогдох санхүүжилт, хүний нөөцийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэх. | Хамааралгүй. | Хамааралгүй | | |
| 8 | Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай<br>2024-08-27<br>Дугаар 2024_21 | 1 | 2.3. 3/Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон жил бүрийн улсын төсөвт тусган хэрэгжүүлэх; | Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл тусгагдаад явж байна. | Хэрэгжсэн | | |
| | | 2 | 2.4. 4/Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнахдаа энэ тогтоолын | Тогтоолын хавсралтын дагуу хяналт, шалгалт хийж байна. | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 2 дугаар хавсралтад заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх; | | | | |
| **Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол** | | | | | | | |
| 9 | Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, хязгаарлах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай<br>2016-04-05<br>Дугаар 2016/10/НББСШУБХ | 1 | 3.1/. Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, ХДХВ/ДОХ-ын тархалтыг бууруулах, хязгаарлах тухай эрсдлийн удирдлагын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, (2018-2020 оны сүрьеэ, бэлгийн замын халдварт өвчний статистик ирүүлэх) | Энэ онд намрын цэрэг татлагаар нийт 82 иргэнд сүрьеэгийн эрт илрүүлэгийн асуумж авсан. Эрт илрүүлгийн асуумжийн үр дүнд бүгд сөрөг буюу эрсдэлгүй гэж гарсан. ХДХВ, Сүрьеэгийн эрсдэл бүхий хүнээс шинжилгээ өвч БОЭТ-рүү илгээж харилцан мэдээллээ солилцон ажиллаж байна. | Хэрэгжсэн | | |
| 10 | Бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай<br>2016-12-14<br>Дугаар 2016/04/НББСШУБХ | 1 | 2.1/. Хүн амын дунд БЗДХ-т өвчин нэмэгдэж байгаатай холбогдуулан аймаг, нийслэл, дүүргийн түвшинд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичигтээ ХДХВ ын халдвар, ДОХ болон БЗДХ-аас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгаж, хэрэгжилтийг хангах; | Намрын цэрэг татлагын ажлын хүрээнд нийт иргэнээс ДОХ, тэмбүүгээр түргэвчилсэн тест авч 100 хувь сөрөг хариу гарсан. | Хэрэгжсэн | | |
| 11 | “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай<br>2018-01-31<br>Дугаар 2018/02/ХЗБХ | 1 | 3.8.. Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, дээрх үйл ажиллагаанд шаардагдах төсөв, хөрөнгийг шийдвэрлэх, дээрх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулахад анхаарах, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл хамтарсан багийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллах, хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, хорооны цагдаагийн алба хаагч, нийгмийн ажилтны орон тоог нэмэгдүүлэх, мэргэжлийн нийгмийн ажилтныг ажиллуулах. | Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгад заасны дагуу сум, хороодод Хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтныг ажиллуулах заалтын хүрээнд 2025 оны 02 дугаар сараас эхлэн Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтныг ажиллуулж байна. Мөн хамтарсан багийн гишүүдийн мэдлэг, ур чадвар болон хүүхэд хамгааллын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор улс, аймгийн хэмжээнд зохион байгуулагдаж буй чадавхжуулах сургалтад тогтмол хамруулж байна. 2025 онд<br>• Хүүхэд гэр бүлийн Нийгмийн ажилтнуудыг чадавхжуулах сургалт<br>• “Кейс менежмент”<br>• “Хүүхэд, гэр бүлийг эрсдэлээс хамгаалах арга зүй” сургалтуудад тус тус | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хамрагдсан байна. Сумын ГХУСАЗСЗ-тэй хамтран гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалт, Гэр бүлийн “Хамдтаа жаргалтай” өдөрлөг, сэтгэл зүйн үйлчилгээ, зөвлөгөө үзүүлэх, бусад нөлөөллийн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж байна. | | | |
| 12 | Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай<br>2020-08-26<br>Дугаар 2020.08.26/01/ИЦББХ | 1 | 3. Бүх шатны боловсролын байгууллагын мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, дэд бүтцийн нөхцөл байдалд үнэлгээ хийж, бэлэн байдлыг үе шаттай хангуулах | ЕБС нь person, eduten олон улсын хөтөлбөрийн хүрээнд бага ангийн цахим ангийг нээсэн. Уг ангид олон улсын хөтөлбөрийн санхүүжилтээр 19 ширхэг нөөтбүүкээр хангасан. | Хэрэгжсэн | | |
| 13 | Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай<br>2021-05-25<br>Дугаар 2021/05/БСШУСБХ | 1 | 1.2/. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний байрыг стандарт, техникийн зохицуулалтад нийцүүлэн шинээр барих, засварлах, өргөтгөх болон стандартын шаардлага хангасан зориулалтын тоног төхөөрөмжөөр хангахад шаардагдах зардлыг шийдвэрлэх; | Орон нутгийн хөгжлийн хөрөнгө оруулалтын сангаар санхүүжилтээр шийдвэрлүүлэхээр төсөл хөтөлбөрөө боловсруулж өгсөн. | Хугацаа болоогүй | | |
| | | 2 | 1.9/. ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдалд мэргэжлийн хяналтийн байгууллагаар үнэлгээ хийлгэж, санал дүгнэлтийг улсын хэмжээнд нэгтгэн гаргаж, цаашид үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангах; | ЕБС-ийн дотоод хяналтын нэгж болон сумын холбогдох мэргэжилтнээр хөндлөнгийн үнэлгээг 2-3 удаа хийлгэсэн. | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | |
| | | 3 | 1.10/. орон нутгийн болон үндэсний үйлдвэрлэлийг дэмжсэн, аюулгүй хүнсний ханган нийлүүлэлтийн тогтолцоог бий болгох, сургуулийн хоол үйлдвэрлэлд ашиглах хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний худалдан авах ажиллагааг ерөнхий гэрээний дагуу зохион байгуулах ажлыг эхлүүлэх; | 2025 оны жилийн эцсийн байдлаар Ерөнхий боловсролын сургууль, Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, Эрүүл мэндийн төв зэрэг төсөвт байгууллагууд мах болон сүү бусад хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний худалдан авалтыг Ерөнхий гэрээний үндсэн дээр зохион байгуулж түүхий эд бүтээгдэхүүнийг худалдан авдаг. Түүхий эд бүтээгдэхүүний итгэмжлэгдсэн лаборторын шинжилгээний бичигтэйгээр бүтээгдэхүүнийг худалдан авдаг. Ерөнхий боловсролын сургууль нь “Итгэл хүнс баялаг” ХХК -тай гэрээ байгуулан мах худалдан авдаг. | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2 | 1.5/. бүх шатны боловсролын сургалтын байгууллагын биеийн тамирын хичээлийн хөтөлбөр агуулгыг боловсронгуй болгох, тоног төхөөрөмж, материаллаг баазыг бэхжүүлэх, суралцагчдыг спортын секц, дугуйланд хамран суралцуулах бололцоог бүрдүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | Сурагчдын хичээлийн хэрэгцээнд зориулсан хувцас, хэрэгсэл, хамгаалах тоноглолыг хангаж, хичээлийн явцыг тасралтгүй байлгах нөхцөл бүрдүүлсэн. ЕБС-ийн спортын секц, дугуйланг өргөжүүлж, суралцагчдын сонирхолд нийцсэн спортын төрлийг нэмэгдүүлсэн. Үүнд: Волейбол, агаарын теннис, шагайн харваа, шатар, даам, үндэсний бөхийн дугуйлан хичээллэж нийт 150 гаруй хүүхэд хамрагдаж байна. Мөн аймаг, улс, бүсийн чанартай тэмцээн уралдаанд оролцоход нь хувцас, шатахуун, хоолны дэмжлэг үзүүлдэг. | Хэрэгжсэн | | |
| | | 3 | 1.6/. Биеийн тамирын багш, дасгалжуулагч, арга зүйч, мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох, тэдгээрийг гадаад улсад бэлтгэх, мэргэшүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | Суманд одоогоор Биеийн тамирын арга зүйчийн орон тоо батлагдаагүй, ЗДТГ-ын Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн хавсран ажиллаж байна. Биеийн тамир спортын газар, БТСУХ-оос зохион байгуулсан чадавхжуулах сургалтад тогтмол хамрагддаг. | Хэрэгжсэн | | |
| | | 4 | 1.12/. Нутгийн өөрөө удирдах байгууллага, бүх шатны засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, иргэдийн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлэх, спортын барилга байгууламж, заал, талбайн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх, жил бүрийн улсын төсвийн төсөлд биеийн тамир спортын салбарын зардлыг нэмэгдүүлэх талаар анхаарч ажиллах. | 2025 оны Орон нутгийн сангийн хөрөнгө оруулалтаар 38,000,000 төгрөгөөр фитнесийн өрөөг тохижуулсан. Фитнес клуб нь 2025 оны 04 дүгээр сарын 22-с эхлэн үйл ажиллагаагаа тогтмол явуулж байгаа бөгөөд тус, өглөө, орой гэсэн 2 ээлжээр, нэг ээлждээ 10-12 хүн хүлээн авч байна. Фитнесийн өрөөнд нэмэлтээр душ, хувцасны өрөөг шийдэж, тохижуулсан. Тогтмол хичээллэдэг иргэдийн тоо 23 байна. | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 14 | Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай<br>2022-04-13<br>Дугаар 2022/04/БОХХААБХ | 1 | 1.4/. Мал, амьтны гоц халдварт өвчний гаралт, тархалтыг таслан зогсоох зорилгоор отор, нүүдэл, шилжилт хөдөлгөөнд тавигдах мал эмнэлгийн болон бусад мэргэжлийн байгууллагуудын хяналтыг сайжруулах талаар онцгой арга хэмжээ авах, зарим эрсдэлтэй бүс нутгийн мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, мал эмнэлгийн хорио цээрийн байнгын болон түр хяналтын цэгийг нэмэгдүүлж, мал эмнэлгийн нэгдсэн бүртгэлийг сайжруулах; | 2025 оны 01 сарын 01-ний өдрөөс хойш нийт 1637 мал эмнэлгийн гэрчилгээ бичигдсэн. Үүнээс 887 нь амьтан хэрэгцээлэх, 683 нь бүтээгдэхүүн, 58 үржил, 9 отор нүүдэл нийт 1637 мал эмнэлгийн гэрчилгээ бичигдсэн. Үүнд хяналт тавьж ажилласан. Илэрсэн зөрчил байхгүй. | Хэрэгжсэн | | |
| | | 2 | 1.5/. Мал амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээний хүрээнд Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль болон Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт үүрэгжүүлж, хуульд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд огцруулах хүртэл хариуцлага тооцох; | Гоц халдварт шүлхий, хоньны цэцэг, бог малын мялзан 3 төрлийн өвчний 5 удаагийн дархлаажуулалт явагдсан. Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад давхардсан тоогоор 462 өрхийн 33787 үхэр, тугал, хоньны цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад давхардсан тоогоор 575 өрхийн 274470 толгой хонь хурга, бол малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 539 өрхийн 119506 хурга ишиг хамруулсан. Дунджаар 99 хувийн гүйцэтгэлтэй ванцинжуулсан. | Хэрэгжсэн | | |
| | | 3 | 1.6/. Малын тоо толгойн албан татварын 50-аас доошгүй хувийг малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд зарцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | Энэ онд байхгүй. | Хэрэгжээгүй | | |
| | | 4 | 1.7/. Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал эмнэлгийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх ажлын хүрээнд вакцин болон халдваргүйтгэлийн бодис, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөцийг бүрэн бүрдүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын төсөвт тусгах; | Бод малын тарилгын хашаа 2, мал эмнэлгийн тасгийн нөөц бүрдүүлэх, мал эмнэлгийн ажил үйлчилгээний шатахуун зардлыг 2026 онд төсөвт суулгахаар хэлэлцэж байна. | Хугацаа болоогүй | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 15 | Чиглэл өгөх тухай<br>2022-06-07<br>Дугаар 2022/14/НББХ | 1 | 1.6/. Улсын хэмжээнд сум бүрийг “Ахмадын өргөө”-тэй болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, Ахмадын өргөөний урсгал зардал, тоног төхөөрөмжийг шийдвэрлэх, ажиллаж буй ахмадын урамшууллыг тухайн орон нутгийн төсөвт тусгаж, санхүүжүүлэх; | Ахмадын өргөөтэй.Халаалтын зардлыг ЗДТГ-аас олгодог, ахмадын урамшууллын зардал 5,0 сая төгрөг төсөвт тусгаж зарцуулсан. | Хэрэгжсэн | | |
| 16 | Чиглэл өгөх тухай<br>2022-06-15<br>Дугаар 2022/07/ҮББХ | 1 | 1.5. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор малын тэжээл тариалах газрын асуудлыг шийдвэрлэх, зуны улиралд сүүний илүүдэлтэй аймгуудад сүү цуглуулах цэг болон боловсруулах үйлдвэрийг кластерын зарчмаар хөгжүүлэх, импортын хуурай сүүг орлох, хадгалалтын хугацаа урттай сүүн бүтээгдэхүүний үйлдвэрийг байгуулах, тоног төхөөрөмжийг шинэчлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх | Зуны хүлэмжийг 2 иргэнд эзэмшүүлэн түрээсийн гэрээг байгуулан нарийн ногоо тариалах дэмжлэг үзүүлэв. 2025 онд 2.53 тонн хүнсний ногоог тариалсан байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 1 иргэнд санхүүжилт олгосон. Энэ онд санхүүжилт төсөвт тусгагдаагүй 18,8 га талбайд ногоон тэжээл тариалж 55 тонны ургац авсан. | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 17 | Чиглэл өгөх тухай<br>2023-03-28<br>Дугаар 2023/05/НББХ | 3 | 1.1.12/. “Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэгт заасан байгууллага бүр хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлэх заалтын хэрэгжилтийг хангуулах хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас хүүхэд хамгааллын бодлого, түүний боловсруулалтын талаар зөвлөмж гаргаж байгууллагуудад хүргүүлэх. | Сумын төсөвт байгууллагуудын “Хүүхэд хамгааллын бодлого” бодлогын хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулсан. Албан байгууллага бүр “Хүүхэд хамгааллын бодлого”-ыг хэрэгжүүлж, хэрэгжилтийн хүрээнд Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3 дахь заалтыг Ажил олгогч нь ажил, амралтын цагийг зохицуулах, хөдөлмөр эрхлэлтийн уян хатан нөхцөл хэрэглэх зэргээр ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгах замаар ажилтны хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлэн, сурталчилан таниулах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. | Хэрэгжсэн | | |
| | | 4 | 1.2.1/. хүүхэд хөгжлийн чиг үүргийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих, Хүүхдийн номын сан, Хүүхэлдэйн театр, Хүүхдийн урлан бүтээх төвийн барилга байгууламжийг шинэчлэх зардлыг улсын төсөвт шат дараатай тусгаж, шийдвэрлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээг бүсчилсэн хэлбэрээр ажиллуулах, хүүхдийн хөгжил төлөвшилд хүрч үйлчлэх нөхцөл бүрдүүлэх; | 2025 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар СӨББ-ын сурагчдын хичээлийн хэрэглэгдэхүүний баазыг нэмэгдүүлэн, хүүхдийн сургалтын орчин, нөхцөлийг сайжруулах арга хэмжээг авч ажилласан. Мөн хүүхдийг урлаг соёлын хөгжүүлэх үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын үйл ажиллагааг дэмжин сум орон нутгийн зүгээс шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнээр хханган ажиллаж байна.<br>Хүүхэд байгууллагуудын үйл ажиллагаанд улирал, жилийн байдлаар | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хяналт-шинжилгээ хийж, хэрэгжилтийг үнэлэн үйл ажиллагааг сайжруулан ажиллаж байна. | | | |
| | | 5 | 1.2.2/. цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдийн нэр төр, алдар хүндэд халдах, гутаан доромжлох, залилах, хүчирхийлэлд уриалах, садар самуун явдлыг сурталчлах зэрэг гэмт хэрэг, зөрчлийн үйлдлүүдийг таслан зогсоох, хууль бус үйл ажиллагаатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг нэн яаралтай авах; | Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга, цахим орчин дахь хүүхэд хамгаалал, насанд хүрээгүй хүүхдийг гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх тухай, насанд хүрээгүй хүүхдийг бэлгийн хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх тухай, цахим орчны зөв зохистой хэрэглээ, цахимд суурилсан хүчирхийлэл зэргээр цахим болон танхимын сургалтыг иргэд олон нийт, бага, дунд, ахлах ангийн сурагчид, зорилтод бүлгүүдэд зохион байгуулсан. Мөн анхан шатны зөвлөгөө, сэтгэл зүйн зөвлөгөөг тогтмол өгч байна. 2025 онд нийт сургалтад хамрагдсан иргэдийн тоо давхардсан тоогоор 1125, зөвлөгөө үйлчилгээ авсан иргэдийн тоо 55 байна. | Хэрэгжсэн | | |
| | | 6 | 1.2.4/. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2016-2022 оны санхүүгийн тайланд аудит хийлгэх, жил бүр хөндлөнгийн хяналт оруулах; | Хэрэгжээгүй. | Хэрэгжээгүй | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | |
| 18 | Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай<br>2023-04-25<br>Дугаар 2023№05 ТБХ | 1 | 6в/. төсвийн үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор төсөв боловсруулах үе шатанд олон нийтийн оролцоог хангах аргуудыг туршилтын журмаар нэвтрүүлэх, Төсвийн ил тод байдлын олон улсын санаачилга /С1оЬа1 1пШайуе Тог Е\|вса1 Тгалзрагелсу/ байгууллагаас гаргасан төсвийн бодлого боловсруулахад олон нийтийн оролцоог хангах зарчмуудыг нэвтрүүлэх, мэдээлэл, харилцаа холбооны олон сувгаар дамжуулан төсвийн төслийн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх, тэдний санал бодлоо илэрхийлэх боломжийг олгох; | Onhs.mof.gov.mn сайтад 2024 оны хэрэгжилт, 2025 оны төлөвлөлт, хэрэгжилт, 2026 оны төлөвлөлтийг бүрэн оруулж, 2026 онд хийгдэх хөрөнгө оруулалтын төлөвлөлтөнд цахим санал асуулга өгөхөд бэлтгэсэн. Нийт цахим санал асуулгад 66 иргэн давхардсан тоогоор 768 санал, нэмэлтээр 22 санал тусгасан байна.(өмнөх оныхоос 46 хувиар өссөн.) | Хэрэгжсэн | | |
| 19 | Засгийн газарт чиглэл өгөх тухай (ЁЗСХБХ)<br>2023-11-01<br>Дугаар 2023_10 | 1 | 1.4. Иргэн төрийн албанд анх ороход тавих ёс зүйн шаардлагыг өндөрсгөх, ёс зүйн зөрчил гаргаж байсан хүнийг төрийн жинхэнэ албанд томилохгүй, албан тушаал дэвшүүлэхгүй байх зарчмыг хатуу мөрдөх; | Шинээр томилогдон ажиллаж буй албан хаагчдын ёс зүйн зөрчил гаргасан эсэх, гэмт хэрэгт холбогдсон эсэх лавлагааг авсны үндсэн томилдог ба 6 хүртэл сарын хугацаанд туршилтаар ажиллуулж байгаад жинхлэн томилж байна. | Хэрэгжсэн | | |
| 20 | Тогтоолын хэрэгжилтийг хангуулах талаар авах арга хэмжээний тухай<br>2024-11-06<br>Дугаар Дугаар 2024_06 ЕЗДБХ | 1 | 1.2. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр” (2024-2030)-ийн хэрэгжилтийг нэгдсэн зохицуулалтаар хангаж, жил бүр тайлагнах; | Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх Үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд төлөвлөгөө боловсруулан үйл ажиллагааны хэрэгжилтийг улирал бүр | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | тайлагнадаг.<br>Төрийн албан хаагчдад чиглэсэн ёс зүйн сургалт зохион байгуулсан.<br>Ёс зүйн зөвлөмж, мэдээллийн самбар, цахим сургалтын материалыг бэлтгэн түгээсэн.<br>Сумын төрийн байгууллагын нийт албан хаагчдын 90%-ийг ёс зүйн сургалтад хамруулсан.<br>Ёс зүйн дэд хороодын 2025 оны төлөвлөгөөний биелэлт 95%-тай байна | | | |
| | | 2 | 1.3 . төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг идэвхжүүлж, төрийн албан хаагчдыг чадавхжуулах, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг таниулах сургалтыг зохион байгуулж, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өргөжүүлж, үр дүнг тайлагнаж ажиллах. | Байгууллагын хамт олны уур амьсгалыг сайжруулах, албан хаагчдын Үндэсний бичгээр унших, бичих чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Ёс зүйн зөвлөлөөс “Эерэг бүхнээ хуваалцъя” уриатай 5 хоногийн CHALLENGE -г зохион байгуулсан. Тус аянд байгууллагын 20 гаруй албан хаагч хамрагдсан.<br>- 2025 оны 01 сарын 07-ны өдөр “Дулаахан яриа” сэдэвт мэргэжлийн Сэтгэл зүйчийн бүлгийн зөвлөгөө, сэтгэл зүйн оношилгоонд хамруулаа. Тус зөвлөгөөнд 6 албан хаагч хамрагдсан.<br>- Ёс зүйн хууль тогтоомжийн талаарх мэдлэг, ойлголтыг иргэд олон нийт болон орон нутгийн байгууллагуудад түгээн сурталчилж, байгууллагын ажилтнуудын ёс зүйг сахих хандлагыг төлөвшүүлэх, ил тод, хариуцлагатай байдлыг бэхжүүлэх зорилгоор “Ёс зүйтэй төрийн алба” уриан дор Ёс зүйн хууль тогтоомж сурталчлах 14 хоногийн аяныг 09 дүгээр сарын 08-ны өдрөөс 09 дүгээр сарын 22-ны өдрийн хооронд зохион байгууллаа. Аяны хүрээнд: Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай, Эергэ харилцаа, хандлага сургалт, Ёс зүйн шийдэл тэмцээн, Шударга төрийн үйлчилгээ эсээ бичлэгийн уралдааныг зохион байгуулсан. Аянд нийт дахардсан | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | тоогоор 100 гаруй албан хаагч хамрагдсан.<br>- Мөн цахим орчинд эерэг хандлага түгээх рийл, видео шторкийг түгээн ажиллаж байна. Нийт хандалтын тоо 100,000 гаруй байна. | | | |
| 21 | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2025-06-10<br>Дугаар 2025_04 ЁЗДБХ | 1 | 1.1.1. 1/Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх Үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлыг төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын жил бүрийн төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг хангаж үр дүнд хяналт тавьж ажиллах; | Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх Үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд төлөвлөгөө боловсруулан үйл ажиллагааны хэрэгжилтийг улирал бүр тайлагнадаг.<br>Төрийн албан хаагчдад чиглэсэн ёс зүйн сургалт зохион байгуулсан. Ёс зүйн зөвлөмж, мэдээллийн самбар, цахим сургалтын материалыг бэлтгэн түгээсэн.<br>Сумын төрийн байгууллагын нийт албан хаагчдын 90%-ийг ёс зүйн сургалтад хамруулсан.<br>Ёс зүйн дэд хороодын 2025 оны төлөвлөгөөний биелэлт 95%-тай байна | Хэрэгжсэн | | |
| | | 2 | 1.1.3. 3/Монгол Улсын ЁС зүйн хорооны гишүүдийн, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх ЁС зүйн дэд хороодын гишүүдийн хараат бус, бие даасан зарчмаар ажиллах нөхцөл, баталгааг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хангах зохицуулалт хийх. | Ёс зүйн дэд хорооны гишүүдийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, гишүүдийн хараат бус, бие даасан байдал, идэвх оролцоо, санаачилгыг үнэлж, ил тод, хариуцлагатай байдлыг хангахын зэрэгцээ цаашдын үйл ажиллагааг сайжруулах, гишүүдийн бүрэлдэхүүнд шинэчлэлт хийх шаардлага байгаа эсэхийг тодорхойлох, байгууллагын албан хаагчдын санал бодлыг сонсох зорилгоор байгууллагын албан хаагчдаас цахим судалгаа авч боловсруулалт хийсэн. Судалгааны дүгнэлтээр Ёс зүйн дэд хорооны гишүүд нь удирдах албан тушаалтан, бусад холбогдох албан тушаалтнаас хараат | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | бус 100% бие даан үйл ажиллагаа явуулдаг гэсэн дүгнэлт гарсан байна. | | | |
| | | 3 | 1.3.1. 1/Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлж, тухайн байгууллагын ЁС зүйн дэд хорооны гишүүдэд олгох урамшууллын асуудлыг шийдвэрлэх, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэн үр дүнг тооцож ажиллах. | Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, үр дүнд үндэслэн журамд заасны дагуу урамшууллыг улирал бүр олгож байна. | Хэрэгжсэн | | |
| **Ерөнхийлөгчийн зарлиг** | | | | | | | |
| 22 | Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай<br>2018-05-23<br>Дугаар 2018_46 | 1 | 3.. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай. | Төсөвт албан байгууллагуудын нэр хаяг кирилл болон үндэсний бичгээр хослуулан бичсэн. Энэ ажлын хүрээнд Засаг даргын Тамгын газар, сургуулийн өмнөх боловсролын байгууллага албан өрөөнүүдээ, ерөнхий боловсролын сургууль хичээлийн байр, дотуур байрны анги танхим, өрөө тасалгаануудын хаяг, мэдээллийн самбаруудыг кирилл болон монгол бичгээр хослуулан бичиж, байршуулсан. Мөн монгол бичгээ дээдэлье, түүхээ мэдэж, эх орноо хайрлая" аяныг зохион байгуулж, төрийн байгууллагуудын албан хаагчдын дунд "Үндэсний бичгийн мэдлэг сорих буухиа" тэмцээнийг зохион байгуулсан. Тус тэмцээнээр 5 багийн 30 төрийн албан хаагч оролцсон. Үүнд<br>- Минутын уншлага<br>- Эх хөрвүүлэг /кириллээс монгол бичиг рүү/<br>- Утга ялгасан үг<br>- Уламжлалт бичлэгтэй үг хөрвүүлэх гэсэн 4 төрлөөр зохион байгуулж. Тэргүүн байр ИТХурал, Соёлын төвийн хамтарсан баг, дэд байранд ЗДТГазар, гутгаар байранд ЕБСургууль орсон. | Хэрэгжсэн | | |
| 23 | Засгийн газарт чиглэл өгөх тухай<br>2019-05-30<br>Дугаар 2019_104 | 1 | 1.16.. Ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулиудын ойр орчмын түргэн хоолны болон түргэн үйлчилгээний цэгт хяналт тавих | Хүнсний дэлгүүрүүдэд улирал бүр эрүүл ахуйн чиглэлээр хариуцсан албан хаагчид хяналт тавин зөрлийг арилгуулан ажиллаж байна. | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 24 | Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/<br>2021-10-04<br>Дугаар 2021_58 | 2 | 1.6. Дүүрэг, сумдад ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулж, иргэдэд мод тарих соёлыг сурталчлан түгээж бүх нийтийн үйлс болгох | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд манай сум Нийтийн эзэмшлийн талбайд шинээр 0.496 га-д 590 мод тарьсан. Мод тарьсан өрхийн тоо-8, ААН байгууллага-3 нийт 1962 ширхэг модыг 1.1 га-д тариалсан байна..Мөн өмнө онуудад тарьсан моднуудаа арчилж, усалж, зарим газруудад нөхөн тарилт хийсэн. Нийтийн эзэмшлийн 1,8 га ногоон байгууламжинд Галт үнэг ХХК-аас 10 сая төгрөгийн санхүүжилтээр нийгмийн хариуцлагын хүрээнд услалтын систем хийж суурилуулж, тухайн талбайд 150ш модыг нөхөн сэргээлт хийсэн. | Хэрэгжсэн | | |
| | | 5 | 2. Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай. | ЕБС-ын сурагчдад 2 удаа, СӨББ-ын хүүхдүүдэд 1 удаа Багийн нийтийн иргэдийн хурлуудаар 5 удаа мэдээ мэдээлэл өгч гарын авлага тараасан. | Хэрэгжсэн | | |
| 25 | Засгийн газарт чиглэл өгөх тухай<br>2022-04-05<br>Дугаар 2022_43 | 1 | 1.8. Иргэд, хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэхэд зохион байгуулалт, хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллагуудыг дэмжин хамтран ажиллах; | Иргэд, хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор байгууллагууд холбогдох бодлого, төлөвлөгөөний хүрээнд зохион байгуулалтын болон боломжит хөрөнгө санхүүгийн дэмжлэгийг үзүүлэн ажиллаж байна. Сумын хэмжээнд спортын | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | талбай, заал, орчны ашиглалтыг сайжруулах, олон нийтийг хамарсан биеийн тамир, спортын арга хэмжээ, тэмцээн уралдааныг зохион байгуулж, хүүхэд залуучуудын оролцоог нэмэгдүүлэв. Мөн энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж, байгууллагуудтай хамтран ажиллаж, тэдний санаачилгыг дэмжин, хамтарсан арга хэмжээ хэрэгжүүлснээр иргэдийн идэвх оролцоо нэмэгдэж, эрүүл амьдралын хэв маяг төлөвшихөд эерэг үр дүн гарч байна. | | | |
| 26 | Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай<br>2022-07-11<br>Дугаар 2022_159 | 1 | 3. Монгол хүн, айл өрх бүр Эзэн Богд Чингис хааны эш хөргийг эрхэмлэн залж, дээдлэн шүтэж байхыг уриалсугай. | Монголын түүх, өв соёл, үндэсний үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор Монгол хүн, айл өрх бүр Эзэн Богд Чингис хааны эш хөргийг эрхэмлэн залж, дээдлэн шүтэж байхыг уриалах чиглэлээр сурталчилгаа, таниулах ажлыг зохион байгууллаа.<br><br>Уг ажлын хүрээнд Чингис хааны түүхэн ач холбогдол, төр ёс, төрт ёсны уламжлалыг иргэдэд таниулж, үндэсний бахархлыг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээллийг түгээн хүргэв.<br><br>Үүний үр дүнд иргэдийн үндэсний үнэт зүйл, түүх соёлоо хүндэтгэх ухамсар нэмэгдэж, өв соёлоо дээдлэн хадгалах үзэл төлөвших нөхцөл бүрдлээ. | Хэрэгжсэн | | |
| | | 2 | 4. Монгол хүн бүр Их Монгол Улсын гал голомтыг сахиж буйгаа гүнээ ухамсарлан, Эзэн Богд Чингис хааны суу алдар, үйл хэрэг, билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган мөрдөж, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээж, эв ээе сахин бататгаж, улс орноо мандуулахад хувь нэмрээ оруулахыг уриалсугай. | Монгол хүн бүр Их Монгол Улсын гал голомтыг сахиж буйгаа ухамсарлан, Эзэн Богд Чингис хааны суу алдар, үйл хэрэг, билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган мөрдөх, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээхийг уриалсан ажлыг зохион байгууллаа.<br><br>Уг ажлын хүрээнд үндэсний бахархлыг | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | төлөвшүүлэх, эв ээ сахин бататгах, улс орныхоо хөгжил, мандалд хувь нэмэр оруулах үзэл санааг иргэдэд таниулж, соёлын сурталчилгаа, арга хэмжээг зохион байгуулсан.<br><br>Үүний үр дүнд иргэдийн түүх, уламжлал, соёлыг эрхэмлэх ухамсар нэмэгдэж, нийгэмд эв ээийг сахин бататгах, улс орныхоо хөгжилд идэвхтэй оролцох нөхцөл бүрдлээ. | | | |
| **Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, тэмдэглэл** | | | | | | | |
| 27 | Газар хөдлөлтийн гамшгаас сэргийлэх тухай<br>2010-03-18<br>Дугаар 2010_10/09 | 2 | 3. Газар хөдлөлтийн аюул, гамшигтай тэмцэх мэдлэг чадвар, дадал эзэмшүүлэх иргэний хамгаалалтын сургалт, дадлагыг улсын хэмжээнд байнга, тогтмол давтамжтайгаар зохион байгуулах, үр дүнг нь тооцдог байх, | Дуут дохио дуугаргаж мэргэжлийн ангиудыг жагсааж газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх гамшгийн төлөвлөгөөг танилцуулсан. ЕБС-ийн сурагчид болон цэцэрлэгийн ахлах бүлгийн хүүхдүүдэд газар хөдлөлтийн үеийн дадлага зохион байгуулсан. | Хэрэгжсэн | | |
| 28 | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2021-09-30<br>Дугаар 2021_03 | 1 | 3.5. Байгаль орчноо хайрлан хамгаалах, зохицон амьдрах, монгол зан заншлыг дээдлэх, уур амьсгалын нөлөөллийг бууруулах, ой мод, усны нөөцийг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор экологийн боловсролыг бүх шатны боловсролын байгууллага болон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан бүх нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээ авах. | ЕБС-ын сурагчдад 2 удаа, СӨББ-ын хүүхдүүдэд 1 удаа Багийн нийтийн иргэдийн хурлуудаар 5 удаа мэдээ мэдээлэл өгч гарын авлага тараасан. | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 3 | 3.10. Хоол, хүнсний зөв, зохистой, соёлтой хэрэглээний талаарх сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг улс орон даяар зохион байгуулах | Тус ажлын хүрээнд 2 багийн 39 өрхөөр биеэр очиж, тус сургалтыг Туяа, Арвайн тал, Хүрэмт, Урт, Их булаг, Алтан тал зэрэг 6 багийн “Иргэдийн нийтийн хурлын” үеэр 297 өрхөөр, 2 удаагийн давтамжтайгаар сургалт зохион байгуулж мэдээлэл хүргэсэн. Бэлтгэсэн материал: хүнсний эрүүл ахуй, хүнсний зориулалтын савны талаар, эрүүл хооллолтын тухай, Органик бүтээгдэхүүний тухай зэрэг 3 төрлийн мэдээллээр 297 ширхэг гарын авлага, эрүүл ахуй, хуванцар савны хэрэглээний талаарх санал асуулга бэлтгэсэн. Видео хичээл: 4 ш. Сургалтад хамрагдсан иргэдийн 50 % нь зохистой хооллолтын дадлыг хэрэгжүүлж эхэлсэн тухайгаа мэдэгдсэн. Санал асуулгыг Хоол хүнсний хэрэглээний талаар, ундны усыг тодорхойлох, эрүүл ахуй, амьдралын хэв маяг, биеийн тамир ба дасгал хөдөлгөөн, эрүүл мэндийн талаарх ойлголт, зэрэг нийт 5 бүлэг асуулгаар 83 өрхөөс туршилтын аргаар авсан. Судалгааны үр дүнд эрүүл мэндийн талаарх ойлголтой эсэх тийм 40 хувь, үгүй 60 хувь, хоол хүнсний талаарх сургалт авах 10 хувь дасгал хөдөлгөөний талаарх 10 хувь тус тус санал өгсөн байна. | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 29 | Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн өнөөгийн баидал цаашид хэрэгжүүлэх арга хэмжээнии тухай<br>2022-11-25<br>Дугаар 2022_03 | 1 | 1.3 . Үндэснии аюулгүй байдлын ашиг сонирхол Монгол Улсын хөгжлийн бодлогод нийцүүлэн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг олгох ажлыг цахим хэлбэрээр сонгон шалгаруулалтын журмаар /нээлттэй болон хязгаарлагдмал/ зохион байгуулах тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээг тухайн сум дүүргийн нутаг дэвсгэрийн 15 хувиас хэтрүүлэхгүй байх; | Хамааралгүй. | Хамааралгүй | | |
| **Засгийн газрын тогтоол** | | | | | | | |
| 30 | Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай<br>2022-01-05<br>Дугаар 2022_7 | 1 | 5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай:<br><br>5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томьёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх;<br><br>5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх;<br><br>5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших;<br><br>5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх;<br><br>5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө | Төсөвт албан байгууллагуудын нэр хаяг кирилл болон үндэсний бичгээр хослуулан бичсэн байгаа. Энэ ажлын хүрээнд ЗДТГазар, СӨББайгууллага албан өрөөнүүдээ, ерөнхий боловсролын сургууль хичээлийн байр, дотуур байрны анги танхим, өрөө тасалгаануудын хаяг, мэдээллийн самбаруудыг кирилл болон монгол бичгээр хослуулан бичиж, байршуулсан. Албан бичгээ бүх байгууллагууд кирилл болон монгол бичгээр хослуулан хэрэглэж байгаа. Төрийн байгууллагууд албан бичгээ кирилл болон монгол бичгээр хослуулан бичих ажлын хүрээнд ЕБСургуулийн сургалтын менежер, Мэдээлэл технологийн багш нар төсөвт албан байгууллагуудын бичиг хэрэг хариуцсан ажилтнууд болон ЗДТГазрын албан хаагч нарт монгол бичгийн Мон скрип программыг албан хэрэглээнд яаж хэрэглэх талаар аргазүйн зөвлөгөө, ЗДТГазраас албан хэрэг хөтлөлтийн стандарт, монгол бичгээр гаргасан албан бичгүүдийг шалган арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх. | | | | |
| 31 | Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл, арга хэмжээг батлах тухай<br>2022-08-24<br>Дугаар 2022_314 | 1 | 2. “Төрөөс дэмжлэг үзүүлэх соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл (2022-2027)”-ийг 1 дүгээр хавсралт, “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжих арга хэмжээ (2022-2030 он)”-г 2 дугаар хавсралт ёсоор тус тус батласугай.<br><br>2. Энэ тогтоолын 1, 2 дугаар хавсралтад заасны дагуу соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүрийн улсын хөгжлийн төлөвлөгөөнд тусгаж, шаардагдах хөрөнгийг улсын төсөв, гадаадын болон олон улсын байгууллага, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Соёлын сайд Ч.Номин, Сангийн сайд Б.Жавхлан нарт, салбарын болон аймаг, нийслэлийн үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган төрийн бус, хувийн хэвшил, хэвлэл мэдээлэл, эрдэм шинжилгээний холбогдох байгууллагууд болон иргэдийг татан оролцуулж, батлагдсан төсвийн багцын дүнд багтаан хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг холбогдох Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | Сумын хэмжээнд тэмдэглэлт баяруud соёлын нэгдсэн арга хэмжээ болон олон талт тэмцээн уралдааныг хамтран зохион байгуулж гүйцэтгэсэн. Үүнд багуудын өдөрлөг номын баяр ойн арга хэмжээнүүд жил бүр хийж ажилласан. 1200 иргэд хамрагдсан. | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | |
| | | 4 | 3. Хот, тосгоны хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд хот байгуулалтын норм, дүрмийн шаардлагыг хангасан цэцэрлэгийн барилгыг тусгасан эсэхэд хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. | Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах тендер зарласан боловч аж ахуйн нэгж орж иргээгүй. | Хэрэгжсэн | | |
| 32 | Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2022-11-23<br>Дугаар 2022_419 | 1 | 3. Энэ тогтоолын 2-т заасан чиглэлийн хүрээнд орон нутгийн хэмжээнд Ажлын хэсэг байгуулж, тодорхой арга хэмжээ авч, шаардагдах эх үүсвэрийг батлагдсан төсөвтөө багтаан санхүүжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.<br><br>/2. Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг шинэчлэн боловсронгуй болгох арга хэмжээний цогц хөтөлбөр боловсруулж, батлуулахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, | Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр сумын аж үйлдвэрийн паркийн зураг төсвийг хийж гүйцэтгүүлсэн. Хуучин ЗДТГ-ын байрыг 60.0 сая төгрөгөөр засварлан ахжуйн үйлчилгээний төв болгохоор тохижуулж бэлэн болгосон. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Арвайхээр Тарагт чиглэлийн 22 км авто замын зураг төсөв хийгдэж 2026 онд авто замын төсөв батлагдсан. Хөдөөгийн хөгжлийн дэмжих чиглэлээр 44 малчинд гар худгийн онгоцыг засварласан. Хөдөөгийн иргэдийн үүрэн телефоны сүлжээг сайжруулах зорилгоор орон нутгийн хөгжлийн санд 60,0 сая төгрөгийг төсөвлөсөн. | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт тус тус үүрэг болгосугай./ | | | | |
| 33 | 2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай<br>2023-02-08<br>Дугаар 2023_49 | 2 | Х-1.3. Төрийн үйлчилгээний хүнд суртал, чирэгдлийг багасгах, иргэд, хувийн хэвшлийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, хамтран ажиллах. | Цахимжсан төрийн үйлчилгээг авах заавар зөвлөгөөг хагас жилийн мал тооллогын ажлаар явахдаа болон багуудын хурал дээр заавар зөвлөгөө өгч ажилласан. ЗДТГ-ын мэдээлэл лавлагааны утас 77327788, Эрүүл мэндийн төвийн 77880018 утсыг ажиллуулж иргэдэд шуурхай мэдээллийг хүргэн ажиллаж байна. Мөн төрийн байгууллага бүр өөрсдийн фэйж хуудас болон Gov.mn сайтад төрийн үйлчилгээний мэдээ, мэдээллийг тогтмол байршуулж байна. | Хэрэгжсэн | | |
| 34 | Хүнсний хангамж, хөдөө аж ахуйн салбарын технологит ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2023-02-08<br>Дугаар 2023_63 | 1 | 3. Мал, малын гаралтай бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлох зорилгоор нийт үхэр сүргийг ялган тэмдэглэж, Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | Энэ онд хэрэгжээгүй. | Хэрэгжээгүй | | |
| 35 | Мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоох тухай<br>2023-04-05<br>Дугаар 2023_119 | 1 | 2. Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн хэлбэрээр хаах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, мөнгөн төлбөрийг төвлөрүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. | 3 иргэнд мөнгөн төлбөрийн торгууль тавигдсан. 1 иргэн 2.2 сая төгрөг төлсөн. | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 36 | Шинжлэх ухаан, технологийн салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай<br>2023-04-05<br>Дугаар 2023_120 | 1 | 2.3. “Хот хөдөөгийн сэргэлт”-ийн хүрээнд нийгэм, эдийн засгийн бүсчлэл тогтоох схем, арга зүй, шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгох, эдийн засгийн өсөлтийн төв боомтуудын тусгайлсан орон зайн хөгжлийн төлөвлөлтийг боловсруулж, дэмжлэг үзүүлж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлийн дарга нарт; | Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр сумын аж үйлдвэрийн паркийн зураг төсвийг хийж гүйцэтгүүлсэн. Хуучин ЗДТГ-ын байрыг 60.0 сая төгрөгөөр засварлан ахжуйн үйлчилгээний төв болгохоор тохижуулж бэлэн болгосон. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Арвайхээр Таргат чиглэлийн 22 км авто замын зураг төсөв хийгдэж 2026 онд авто замын төсөв батлагдсан. Хөдөөгийн хөгжлийн дэмжих чиглэлээр 44 малчинд гар худгийн онгоцыг засварласан. Хөдөөгийн иргэдийн үүрэн телефоны сүлжээг сайжруулах зорилгоор орон нутгийн хөгжлийн санд 60,0 сая төгрөгийг төсөвлөсөн. | Хэрэгжсэн | | |
| 37 | Боловсролын салбарын хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2023-07-05<br>Дугаар 2023_266 | 1 | 3. Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын ашиглалттай холбогдон гарах зардлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу жил бүрийн орон нутгийн төсөвт тусган, засвар үйлчилгээг хариуцаж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай | ЕБС 2024-2025 оны хичээлийн жилд ариун цэврийн байгууламж улсын төсвөөр бүрэн хийгдсэн. | Хэрэгжсэн | | |
| 38 | Журам шинэчлэн батлах тухай<br>2023-07-19<br>Дугаар 2023_278 | 1 | 2. Энэ журмыг хэрэгжүүлж ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай.(1."Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам) | Жил бүр орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжих төсөл хөтөлбөрт иргэдээс санал авч БИНХ-аар хэлэцүүлэн Иргэлийн Төлөөлөгчдийн хурлаар төсвийг батлуулан хэрэгжилтийг тухай бүр иргэдэд тайлагнан ажиллаж байна. | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 39 | Нийслэл Улаанбаатар хотод гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гамшгийн хор уршгийг арилгах, нийслэлийн хот төлөвлөлт, газар зохион байгуулалттай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай<br>2023-08-16<br>Дугаар 2023_294 | 1 | 3. 3.Аймаг, сум, чөлөөт бүсийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдаагүй, тусгагдсанаас өөр зориулалтаар газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахгүй байхыг аймаг, сумын Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч нарт үүрэг болгосугай. | Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй газрыг олгохгүй байх ажлыг ханган ажиллаж байна. | Хэрэгжсэн | | |
| 40 | Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн зарим арга хэмжээний тухай<br>2023-08-30<br>Дугаар 2023_321 | 1 | 2. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг харьяалах салбар, нутаг дэвсгэртээ зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, шаардагдах зардлыг төсвийн ерөнхийлөн захирагч нарын саналыг харгалзан улсын нэгдсэн төсвийн төсөлд тусган, хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхланд даалгасугай. | Тарваган тахал өвчинөөс урьдчилан сэргийлэх сургалт хийж, нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулсан. Сургалтанд 72 хүн хамрагдсан. 2. Эмийн зохистой хэрэглээний дэлхийн 10 хоногийн аяны хүрээнд “Зөв цагт, зөв тунгаар” уриан дор ЭМТ-д хэвтэн эмчлүүлэгчид болон үйлчлүүлэгчидтэй уулзаж сургалт болон боршур тарааж мэдээлэл хүргэсэн. 3 хэвтэн эмчлүүлэгч, 21 үйлчлүүлэгчид мэдээлэл хүргэж, 20 боршур тараасан. Чихрийн шижин өвчинтэй тэмцэх дэлхийн нийтийн өдрийг үндэслэн ЭМТ-өөр үйлчлүүлэгчидэд мэдээлэл сургалт хийсэн. Цахим орчинд мэдээлэл байршуулж олон нийтэд зөвлөмж хүргэсэн. Мэдээллийг 784 хүн үзэж, 4-н хандалт, 1 удаа хуваалцсан үзүүлэлттэй байна. Халдварт өвчинтэй тэмцэх , сэргийлэх арга хэмжээний хүрээнд Томуу, томуу төст өвчиний урьдчилан сэргийлэх ажлыг ЭМТ эмч мэргэжилтнүүдийн хамтаар хийж. СӨБ болон ЕБС-ийн байгууллагуудад сургалт, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Сургалтанд 8 ажилтан, СӨБ-ын 20 хүүхдийн эцэг эх хамрагдав. Ахлах сувилагч С.ОРОЛМАА хамт ЕБС-ийн дотуур байрны сурагчдад амны хөндийн ариун цэвэр шүдний оо болон сойзыг зөв ашиглах хэрхэн сонгох талаар сургалт орж эрүүл мэндийн боловсрол олгож ажилласан сургалтанд 49-н хүүхэд 1 | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ажилчин хамрагдсан. Эрүүл мэндийн боловсрол дээшлүүлэх ажлын хүрээнд хувийн ариун цэвэр сахиулах талаар сургалт зөвлөгөө өгч, дотуур байрны хүүхдүүдийг ахлах сувилагчийн хамтаар үзлэг хийж шаардлагатай гэж үзсэн хүүхдүүдэд нэмэлт зөвлөгөө хүргэж ажилласан. Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих зорилгийн хүрээнд ЭМТ-ийн ажилчдын дунд Ёс зүйн дэд хороотой хамтран салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулан ажилчидтайгаа кофетой өглөөний уулзалтыг зохион байгуулж, ажилчид өөрсдийн санаачлагаар хөгжөөнт тоглоом тоглуулах ёс зүйн төлөвшил түгээлэх ажил зохион байгуулж хамтын санаачлага хөдөлмөрөөр эрх зүйн орчин сайжруулах, хамт олон нийгэмийн сэтгэл ханамжийн нөхцөл сайжруулах ажил хийж ажлын байран дахь сэтгэл зүй, сэтгэл ханамжтай орчин сургалт мэдээлэл хүргэсэн. | | | |
| 41 | “Эрүүл шүд” арга хэмжээг хэрэгжүүлэх тухай<br>2023-08-30<br>Дугаар 2023_322 | 1 | 2. Сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон ерөнхий боловсролын сургуульд өдөр бүр “Шүд угаах цаг”-ийг бий болгон хэвшүүлж, эрүүл ахуйн шаардлага хангасан шүдээ угаах хэсэг бий болгох ажлыг үе шаттайгаар улс, орон нутгийн төсвийн болон гадаадын зээл тусламжийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр тусгаж, холбогдох арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | ЕБС-ийн бага ангийн 102 сурагчид үдийн цай хоол хөтөлбөрийн өмнө шүдээ тогтмол угааж хэвшсэн. | Хэрэгжсэн | | |
| 42 | Тоггоолын хавсралт өөрчлөн батлах тухай<br>2024-02-28<br>Дугаар 2024_82 | 1 | 2. Төрийн албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдлийг олгоход шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. /2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс | Төрийн захиргааны албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг 60 хувиар олгосон. | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хойш тайлагнах/ (1.“Журам батлах тухай” Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам”-ыг хавсралт ёсоор өөрчлөн батлалсугай.) | | | | |
| 43 | Журам батлах, журмын хавсралтад өөрчлөлт оруулах тухай<br>2024-02-28<br>Дугаар 2024_83 | 1 | 3. Мөнгөн урамшуулал олгоход 2024 онд шаардагдах хөрөнгийг тухайн төрийн захиргааны байгууллагын төсвийн захирагчийн батлагдсан төсөвт багтаан, цаашид жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг төсвийн захирагч нар, Сангийн сайд Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай. (1.“Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ыг хавсралт ёсоор батлалсугай.) | Төрийн захиргааны албан хаагчдыг хагас бүтэн жилээр гүйцэтгэлийн үнэлгээг үндэслэн үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон. | Хэрэгжсэн | | |
| 45 | Зүй бусаар хорогдсон малын сэг зэм устгах, мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай<br>2024-04-24<br>Дугаар 2024_173 | 1 | 1. Хүн, мал, амьтны халдварт өвчин дэгдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор зүй бусаар хорогдсон малын сэг зэмийг зохих журмын дагуу устгах, орчны цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэл хийх арга хэмжээг 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор зохион байгуулахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ нарт тус тус даалгасугай | Энэ онд нийт 1275 мал, амьтны сэг зэм устгасан. Нийт 20,0 мянган метр квадрат хашаа хороо, худаг ус, цэг, байр саравч, бэлчээрийн талбай халдваргүйтгэсэн. | Хэрэгжсэн | | |
| | | 2 | 2. Малын сэг зэмийг устгах, ариутгал, халдваргүйтгэл хийх арга хэмжээний зардлыг орон нутгийн төсөвтөө зохицуулалт хийх замаар шийдвэрлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, иргэд, малчидтай орон нутгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсээр дамжуулан байгуулах гэрээт ажлын хөлсийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зохих журмын дагуу гаргахыг | 2026 оны төсөвт сэг зэм устгалын зардлыг оруулахаар санал оруулсан байна. | Хугацаа болоогүй | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяад тус тус даалгасугай | | | | |
| 46 | Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 2024-05-01 Дугаар 2024_187 | 1 | 4.б. Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан 2024 онд мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар малчдын хоршоонд эзэмшүүлэх газрыг тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, газар эзэмшүүлэх асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэхийг аймаг, нийслэл, сумын Засаг дарга нарт, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд тухай бүр нь дүгнэлт гаргаж ажиллахыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар (А.Энхманлай)-т тус тус даалгасугай | Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр сумын аж үйлдвэрийн паркийн зураг төсвийг хийж гүйцэтгүүлсэн. Хуучин ЗДТГ-ын байрыг 60.0 сая төгрөгөөр засварлан ахжуйн үйлчилгээний төв болгохоор тохижуулж бэлэн болгосон. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Арвайхээр Тарагт чиглэлийн 22 км авто замын зураг төсөв хийгдэж 2026 онд авто замын төсөв батлагдсан. Хөдөөгийн хөгжлийн дэмжих чиглэлээр 44 малчинд гар худгийн онгоцыг засварласан. Хөдөөгийн иргэдийн үүрэн телефоны сүлжээг сайжруулах зорилгоор орон нутгийн хөгжлийн санд 60,0 сая төгрөгийг төсөвлөсөн. | Хэрэгжсэн | | |
| 47 | Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим системийн талаар авах арга хэмжээний тухай 2024-05-08 Дугаар 2024_196 | 1 | 3.“Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим систем”-ийг ашиглан эрхлэх асуудлынхаа хүрээндээ төрийн албан хаагчийн мэдээллийн бүрдүүлэлт, үнэн зөв байдалд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай | Цахим системд төрийн албан хаагчийн мэдээллийг тухай бүр мэдээллийг шинэчлэн баталгаажилтыг хийлгэсэн. | Хэрэгжсэн | | |
| 48 | Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2025 оны төсвийн хязгаарыг батлах тухай 2024-07-24 Дугаар 2024_10 | 1 | 2.Энэ тогтоолоор баталсан төсвийн хязгаарт нийцүүлэн 2025 оны төсвийн төслийг боловсруулахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | 2025 онд төсвийн төслийг хязгаарт багтаан боловсруулж батлуулсан. | Хэрэгжсэн | | |
| 49 | Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай 2024-08-07 Дугаар 2024_28 | 1 | 3.1.“Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоол, “Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аяныг зарлах тухай" Засгийн газрын 2019 оны 476 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх | Сумын хэмжээнд нийт 5 хүнсний худалдааны цэг, салбаруудаас долоо хоног бүр хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийн мэдээллийг цуглуулж, нэгтгэн Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүнд: гурил, мах, будаа, элсэн чихэр, сүү, ургамлын тос, цэвэр ус, төмс, | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хүрээнд атар газрыг тариаланд шилжүүлэх ажлыг орон нутгийн түвшинд зохион байгуулах; | хүнсний ногоо, өндөг, гурилан бүтээгдэхүүн зэрэг бүтээгдэхүүнүүд багтсан. Сумын хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах 6 бүлэг, 11 зорилт, 21 арга хэмжээ бүхий 5 жилийн төлөвлөгөөг холбогдох мэргэжлийн байгууллагууд хамтран хэрэгжүүлэн ажиллаж байна. Сумын хүн амын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний тэнцэлийг улирал тутамд тооцож, аймгийн Хүнс, хөдөө аж ахуй газарт хүргүүлсэн. Хүнсний бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэл, хангамжийн урьдчилсан гүйцэтгэлийг урд онтой харьцуулахад хүн амын хэрэгцээт мах, сүүг 90 хувь, дотоодын үйлдвэрлэлээр хангаж байна. Төмс, хүнсний ногооны тариалалт муу байгаа тул хэрэгцээгээ хангаж чадаагүй байна. | | | |
| | | 2 | 3.2.Энэ тогтоолын хавсралтаар батлагдсан аймаг, нийслэл, сум, дүүргийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх, отор нүүдлийг тогтоосон чиглэлийн дагуу явуулах, мал эмнэлгийн хорио цээрийн хяналт шалгалтыг эрчимжүүлж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах; | Хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах тухай Аймгийн Засаг даргын 2025.09.03 -ны өдрийн А/553 дугаар захирамжийн хавсралтаар сумын аюулгүй нөөцөд өвс 122.4 тонн, тэжээл 106.1 тонн бэлтгэвэл зохих төлөвлөгөөний дагуу өвс 27,5 тонн, хивэг 8.7 тонн, овьёос 12,5 тонн, ногоон тэжээл 3 тонн үлдэгдэлтэй байсан. Нэмэлтээр 5 тонн өвс худалдан авч сумын аюулгүй нөөцийг бүрдүүлсэн. | Хэрэгжсэн | | |
| | | 3 | 3.3. Улсын тусгай хамгаалалттай болон хилийн зурвас газарт отроор өвөлжиж, хаваржих малчин өрх, малын тооны судалгааг урьдчилан гаргаж, холбогдох төрийн байгууллагын зөвшөөрөл, гэрээний дагуу босоо чиглэлд отроор өвөлжүүлж, хаваржуулах ажлыг зохион байгуулах; | Булган аймагт 1 өрх, аймгийн бусад сумдад 17 малчин өрх оторлосон. | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 4 | 3.4. “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд хэрэгжүүлэх төслийг орон нутгийн хөгжлийн болон бэлчээр ашиглалт, газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан мал аж ахуйн салбарын үндсэн хөрөнгө, бүтээн байгуулалтын чиглэлд хандуулах; | Малчид хоршооны үйл ажиллагаанд итгэх итгэл нэмэгдэж, "Шинэ-Хоршоо" хөдөлгөөнд шинээр 23 өрх нэгдсэн. Тус шинээр байгуулгагдсан хоршоодын нарийвчилсан судалгааг гарган мэдээллийн бааз үүсгэсэн. Хоршооны нийт гишүүдийн тоо 430-аар нэмэгдсэн. Шинэ хоршоодын мал аж ахуй, түүхий эд боловсруулах чиглэлээр ихэнх хувийг эзэлж байна. 47 шинэ хоршоонд хоршоо үүсгэн байгуулах тухай хурлын талаарх мэдээллийг хүргэж 5 хоршооны үүсгэн байгуулах бүх гишүүдийн хуралд биечлэн оролцсон. Хоршооны санхүүгийн үйл ажиллагааг хэрхэн бүртгэх талаар зааварчилгаа өгсөн. Хоршооны татварын хууль, боломжит хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаар мэдээлэл өгсөн. “Хоршооны тухай” хуулийн 2 видео танилцуулга, 2 төрлийн гарын авлагыг бэлтгэн цахимд байршуулсан. Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр сумын аж үйлдвэрийн паркийн зураг төсвийг хийж гүйцэтгүүлсэн. Хуучин ЗДТГ-ын байрыг 60.0 сая төгрөгөөр засварлан ахжуйн үйлчилгээний төв болгохоор тохижуулж бэлэн болгосон. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Арвайхээр Тарагт чиглэлийн 22 км авто замын зураг төсөв хийгдэж 2026 онд авто замын төсөв батлагдсан. Хөдөөгийн хөгжлийн дэмжих чиглэлээр 44 малчинд гар худгийн онгоцыг засварласан. Хөдөөгийн иргэдийн үүрэн телефоны сүлжээг сайжруулах зорилгоор орон нутгийн хөгжлийн санд 60,0 сая төгрөгийг төсөвлөсөн. | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 50 | Цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тооны дээд хязгаарыг тогтоох тухай<br>2024-08-28<br>Дугаар 2024_52_1 | 1 | 2.. Цэргийн дүйцүүлэх албыг зохих журмын дагуу зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. | 2025- 2027 онд 5 иргэн дүйцүүлэхээр алба хааж байна. | Хэрэгжсэн | | |
| 51 | Төрийн байгууллагын үйл ажиллагааны цахим шилжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай<br>2024-11-13<br>Дугаар 2024_163 | 1 | 3. Төрийн албан хаагчдын цахим ур чадварыг сайжруулах сургалтын хөтөлбөрийг боловсруулж, сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэхийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүүд даалгасугай. | Төрийн албаны зөвлөлөөс 7:4:10 сургалтын хүрээнд ai хиймэл оюун ухааны сургалтыг цахимаар зохион байгуулсан. | Хэрэгжсэн | | |
| 52 | Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай<br>2024-12-25<br>Дугаар 238 | 1 | 2. Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлж, 2025 онд орон тооны дээд хязгаарыг нэмэгдүүлэхгүй байхыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | Цалингийн шинэчилсэн доод хэмжээгээр албан хаагчдад цалин хөлсийг сар бүр олгож байна. Шинээр орон тоо нэмэгдээгүй. | Хэрэгжсэн | | |
| 53 | Хүүхдийн эрхийг хамгаалах зарим арга хэмжээний тухай<br>2025-01-29<br>Дугаар 41 | 1 | 3. Хүүхдийн эрхийг хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах, хүүхэд оролцуулах соёл, спортын арга хэмжээний зохион байгуулалт, хяналтын үйл ажиллагаанд орон нутгийн удирдлага болон мэргэжлийн холбоодын оролцоог хангах зарчимд нийцүүлэн холбогдох журмыг шинэчлэх арга хэмжээ авахыг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан нарт даалгасугай. | Хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд: Багийн иргэдийн нийтийн хуралдаанаар иргэдэд “Хүүхэд хамгааллын тухай хууль”, “Хүүхдийн хүмүүжлийн эерэг арга”, “Цахим орчин дахь хүүхэд хамгаалал” сургалтуудыг зохион байгуулан, EKIDS аппликэйшн, Хүүхдийн тусламжийн 108 утсыг сурталчлах арга хэмжээг зохион байгуулсан.<br>Гамшиг онцгой байдлын үе дэх хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн ангийн үйл ажиллагааг идэвхжүүлэн ажиллах ажлын хүрээнд: ЕБС-ийн дэргэдэх Эко клубийн сурагчидтай хамтран Хүүхэд залуучуудад байгаль орчинтой зөв харьцах, гамшиг, ослын үед авах арга хэмжээний талаар сургалт зохион | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | байгуулан, гамшгийн үеийн бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байна. "Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт"-ыг иргэдэд таниулах сурталчлах, хэрэгжилтийн байдалд хяналт шалгалт хийх, зөвлөмж мэдээлэл өгөх, салбар дундын үйл ажиллагааг нэмэгдүүлэх ажлын хүрээнд: ЕБС-ийн нийгмийн ажилтантай хамтран сургуулийн орчинд “Сэргийлэгч хүү”, “Зөвлөгч охины” дүрийг хэвлэн байршуулсан. Мөн хүүхэд ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтын хэвлэмэл хуудсыг байршуулсан. Үндэсний морин уралдааны морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавигдах шаардлага MNS 6715:2019 стандарт, ЗГ-ын 2019 оны 57 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллах ажлын хүрээнд: Сумын баяр наадам, 6 багийн өдөрлөг, авто тээврийн салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойн баяр наадам зэрэг нийт 8 наадамд давхардсан тоогоор 320 хүүхдийн хамгаалах хэрэгсэл, даатгал, бие, сэтгэл зүйн эрүүл мэндэд хяналт тавьж ажилласан. Уралдааны явцад 6 хүүхэд мориноос унасан тохиолдол гарсныг эрүүл мэндийн төвөөс ажилласан эмч анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлсэн. | | | |
| | | 2 | 4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Монгол Улсын сайд, Хяналт үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, бүх шатны Засаг дарга нарт тус тус даалгасугай. | Сургалт, соёл, спортын арга хэмжээг орон нутгийн удирдлага болон мэргэжлийн холбоодын оролцоотой зохион байгуулж, хүүхэд хамгааллын тухай хууль, хүүхэд хамгааллын бодлогыг баримтлан ажиллаж байна. | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 54 | Яаралтай тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2025-02-05<br>Дугаар 67 | 1 | 3. Орон нутагт яаралтай тусламжийн дуудлага, мэдээллийг нэгдсэн "112" дугаарлалтаар хүлээн авах үйл ажиллагааг Теле камерын хяналтын дэд төвүүдийн үйл ажиллагаатай уялдуулах арга хэмжээ авахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, аймгийн Засаг дарга нарт даалгасугай. | Unitel ХХК-аас 10,3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар теле камерын холболтын ажлыг хийсэн. 2026 онд сарын суурь хураамжийг төсөвт батлуулснаар бэлэн болно. | Хэрэгжсэн | | |
| 55 | Экспортын орлогыг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай<br>2025-02-19<br>Дугаар 94 | 1 | 4. Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, хөрөнгө оруулалт татах зорилгоор гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж болон иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэж ажиллахыг бүх шатны төрийн захиргааны байгууллагад үүрэг болгосугай. | Энд гадаадын хөрөнгө оруулалтын санал санаачилга орж ирээгүй. | Хэрэгжээгүй | | |
| 56 | Монгол Улсын иргэнд онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай<br>2025-03-06<br>Дугаар 119 | 1 | 2. Энэ тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар (А.Энхманлай), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | Сумын хэмжээнд сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийгдээгүйтэй холбогдуулан тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд газар өмчлөлт хийгдээгүй байна. | Хугацаа болоогүй | | |
| 57 | Улсын хэмжээнд 2025 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт батлах тухай<br>2025-03-06<br>Дугаар 120 | 1 | 2. Энэ тогтоолоор баталсан жагсаалтад тусгагдсан байршилд газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахдаа холбогдох хууль тогтоомж, журмыг баримталж, газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн системээр дамжуулан хэрэгжүүлэх арга хэмжээ авч, жагсаалтад тусгагдаагүй байршилд газар эзэмшүүлэх, ашиглуулах аливаа шийдвэр гаргахгүй байхыг Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, сум, нийслэлийн Засаг дарга, Чөлөөт бүсийн захирагч нарт тус тус үүрэг болгосугай. | Газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахдаа холбогдох хууль тогтоомж, журмыг баримталж, газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн системээр дамжуулан хэрэгжүүлэх арга хэмжээ авч, жагсаалтад тусгагдаагүй байршилд газар эзэмшүүлэх, ашиглуулах аливаа шийдвэр гаргахгүй ажиллаж байна. | Хэрэгжсэн | | |
| | | 2 | 3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Газар зохион байгуулалт, | Тухай бүр нь хэрэгжүүлэн ажиллаж байна. | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | геодизи, зураг зүйн ерөнхий газар (А.Энхманлай)-т даалгасугай. | | | | |
| 58 | Мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоох тухай<br>2025-03-19<br>Дугаар 141 | 1 | 2. Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр олуулан хаах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, мөнгөн төлбөрийг төвлөрүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. | Мөнгөн төлбөр 3 иргэнд тавигдсан. Үүний 1 нь төлбөрөө бүрэн барагдуулсан. | Хэрэгжсэн | | |
| 59 | 2026 оныг "Боловсролыг дэмжих жил" болгон зарлах тухай<br>2025-04-02<br>Дугаар 158 | 1 | 2. "Боловсролыг дэмжих жил"-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан Засгийн газарт танилцуулахыг Боловсролын сайд П.Наранбаяр, Боловсролын Үндэсний зөвлөлд тус тус даалгасугай. | Хугацаа болоогүй. | Хугацаа болоогүй | | |
| | | 2 | 3. Боловсролыг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, бүх талын дэмжлэг үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. | Хугацаа болоогүй. | Хугацаа болоогүй | | |
| | | 3 | 4. Боловсролыг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа, арга хэмжээг улсын хэмжээнд нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Боловсролын сайд П.Наранбаяр, холбогдох санхүүжилтийг 2026 оны улсын төсвийн төсөлд тусган шийдвэрлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавихыг Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, салбар дундын уялдааг хангаж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал нарт тус тус даалгасугай. | Хугацаа болоогүй. | Хугацаа болоогүй | | |
| 60 | Хүн ам, орон сууцны завсрын тооллого явуулахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай | 1 | 2. Хүн ам, орон сууцны 2025 оны завсрын тооллогод ашиглах мэдээллийн сангийн мэдээллийн чанарыг сайжруулах, | 2025 оны хүн ам, орон сууцны завсрын тооллогыг зохион байгуулах сумын Засаг даргын А/127 дугаар захирамжаар | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 2025-05-28<br>Дугаар 260 | | шинэчлэх, баталгаажуулах арга хэмжээг харьяа нутаг дэвсгэртээ зохион байгуулж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. | комисс байгуулан тооллогын бэлтгэл ажил болон мэдээллийг шинэчлэх арга хэмжээг хийж ажилласан. Завсрын тооллогоор сумын хэмжээнд өрхийн болон биечлэн тодруулгад нийт 655 өрхийн мэдээллийг шинэчлэл хийж ажилласан. Мөн сумын төрийн байгууллагуудын нийт 113 албан хаагчдаасÂ 98 албан хаагчдыг төрийн үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia болон https://2025.mn цахим хуудсаар дамжуулан өөрийн болон өрхийн гишүүд суупцны мэдээллийг шинэчлүүлэн баталгаажуулсан. Багийн засаг дарга нар 655 өрхийн тодруулгыг тус бүр шинэчлэн 12 сарын 05-ны дотор 100 хувь хийж дуусгасан. Завсрын тооллогын зардалд нийт 1,085,531 төгрөг хуваарилагдаж ирсэн. | | | |
| 61 | Ажил, амралтын цагийн зохицуулалтын тухай<br>2025-06-04<br>Дугаар 279 | 1 | 1. Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баярын 2025 оны 07 дугаар сарын 12, 13-ны өдрүүд нь Бямба, Ням гарагт тохиож байгаатай холбогдуулан 2025 оны 07 дугаар сарын 16, 17-ны өдрийн Лхагва, Пүрэв гарагт ажилтан, албан хаагчдыг амрааж, 2025 онд багтаан нөхөн ажиллуулах зохицуулалт хийхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад даалгасугай. | Хуваарын дагуу албан хаагчдын амраасан. | Хэрэгжсэн | | |
| 62 | Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2026 оны төсвийн хязгаарыг батлах тухай<br>2025-06-18<br>Дугаар 01 | 1 | 2. Энэ тогтоолоор баталсан төсвийн хязгаарт нийцүүлэн 2026 оны төслийг боловсруулахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | 2026 оны төсвийг хязгаарт багтаан төлөвлөсөн. | Хэрэгжсэн | | |
| 63 | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2025-07-23<br>Дугаар 29 | 1 | 1.6. хүүхэд, залуучуудын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд чиглэсэн соёл, спорт, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлж, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгийг олон | Хүүхэд, өсвөр үеийнхнийг газ, бензин бусад төрлийн мансууруулах бодис үнэрлэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор сумын төвийн 4 худалдаа эрхлэгчид насанд хүрээгүй хүүхдэд | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | нийтэд тайлбарлан ойлгуулах ажлыг тогтмол зохион байгуулахыг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Ундрам, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | ахуйн хэрэглээний газ худалдан борлуулахгүй байх анхааруулга санамж хүргүүлж. Мөн иргэдэд хүүхэд ахуйн хэрэглээний газ, бензин үнэрлэснээсүүдэн гарах хор хөнөөл, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөний талаар гарын авлага тарааж мэдээлэл хүргэсэн.<br>2. Хүүхдийг хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, зөв дадал хэвшил төлөвшүүлэх зорилгоор сургалт зохион байгуулсан. Сургалтын үеэр тамхи, архи, мансууруулах бодис зэрэг хорт зуршлын хүний эрүүл мэнд, зан төлөв, амьдралын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийн талаар мэдлэг олгож, хорт зуршлаас ангид байх, зөв амьдралын хэв маягт суралцахын ач холбогдлыг онцоллоо. Уг үйл ажиллагаанд нийт 33 сурагч идэвхтэй хамрагдаж, өөрсдийн санал бодлоо солилцон, асуулт асууж, танин мэдэхүйн мэдлэгээ тэллээ. | | | |
| | | 2 | 3. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх арга хэмжээний хэрэгжилтийг хангах хүрээнд бүх талын дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. | Сумын төвийн худалдаа эрхлэгч нарт насанд хүрээгүй хүүхдэд ахуйн хэрэглээний газ худалдан борлуулахгүй байх анхааруулга санамж хүргүүлж. Мөн иргэдэд хүүхэд ахуйн хэрэглээний газ, бензин үнэрлэснээсүүдэн гарах хор хөнөөл, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөний талаар гарын авлага тарааж мэдээлэл хүргэсэн. Хүүхдийг хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, зөв дадал хэвшил төлөвшүүлэх сургалт зохион байгуулсан. Сургалтын үеэр тамхи, архи, мансууруулах бодис зэрэг хорт зуршлын хүний эрүүл мэнд, зан төлөв, амьдралын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийн талаар мэдлэг олгож, хорт зуршлаас ангид байх, зөв амьдралын хэв маягт суралцахын ач холбогдлыг онцоллоо. Сургалтад 33 сурагч хамрагдсан. | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 64 | Хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай<br>2025-08-20<br>Дугаар 56 | 4 | 2.6.. улсын тусгай хамгаалалттай болон хилийн зурвас газарт отроор өвөлжиж, хаваржих малын тоо, малчин өрхийн судалгааг нарийвчлан гаргаж, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, орон нутгаас гаргасан судалгаанд үндэслэн отроор өвөлжүүлж, хаваржуулах боломж, нөхцөлийг бүрдүүлэхийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Хил хамгаалах ерөнхий газар (Ж.Бямбасүрэн)-т; | Гадны аймагт өвөлжиж байгаа отор энэ жил байхгүй. Өөрийн аймгийн Баруунбаян-Улаан, Зүүн баян-Улаан суманд нийт 31 өрхийн мал оторлож байна. | Хэрэгжсэн | | |
| | | 5 | 2.7.. аймгийн болон сум дундын отрын бүс нутаг шинээр бий болгох тооцоо, судалгаа хийж, хэрэгжилтийг зохион байгуулахыг аймгийн Засаг дарга нарт; | Сумын хэмжээнд бусад сум, аймагт отроор явсан малчин өрхийн тоо 29 байна. | Хэрэгжсэн | | |
| | | 6 | 2.10.. энэ тогтоолын хавсралтаар заасан өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлж, мал эмнэлгийн хорио, цээрийн хяналт шалгалтыг эрчимжүүлэн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | Хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах тухай Аймгийн Засаг даргын 2025.09.03 -ны өдрийн А/553 дугаар захирамжийн хавсралтаар сумын аюулгүй нөөцөд өвс 122.4 тонн, тэжээл 106.1 тонн бэлтгэвэл зохих төлөвлөгөөний дагуу өвс 27,5 тонн, хивэг 8.7 тонн, овьёос 12,5 тонн, ногоон тэжээл 3 тонн үлдэгдэлтэй байсан. Нэмэлтээр 5 тонн өвс худалдан авч сумын аюулгүй нөөцийг бүрдүүлсэн. | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 8 | 2.14.. улсын хэмжээнд шаардлагатай улаанбуудай, төмс, хүнсний ногоо, өвс, тэжээлийн хэрэгцээ, хангамжид үндэслэн гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний экспорт, импортын зохистой харьцааг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаярт, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний дотоодын нөөцийг бүрдүүлж, нийлүүлэлтийг тасалдуулахгүй байхад анхаарч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | Энэ жил манай сумын төмс тарьсан нийт талбай 10.2 га-д, төмс хураасан нийт ургац 87.4 тн, Хүнсний ногоо тарьсан нийт талбай 8.78 га-д хүнсний ногоо хураасан ургац 89.67 тн ургац хураан авсан байна. | Хэрэгжсэн | | |
| | | 10 | 2.19.. цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх мэдээг малчид, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд цаг алдалгүй, шуурхай хүргэх арга хэмжээ авч ажиллахыг Цаг уур, орчны шинжилгээний газар (Э.Баттулга), аймгийн Засаг дарга нарт. | Мэргэжлийн байгууллагаас гаргасан цаг уурын мэдээллийг малчид иргэдэд цахим хуудсаар болон багийн Засаг дарга нараар дамжуулан хүргэж байна. | Хэрэгжсэн | | |
| | | 11 | 3.. Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах, хүндрэл багатай даван туулахад шаардлагатай санхүүжилтийг батлагдсан төсөвтөө багтаан шийдвэрлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | Өвөлжилтийн бэлтгэл ажилд зориулан Засаг даргын нөөц хөрөнгөөс 4,0 сая төгрөг зарцуулсан. | Хэрэгжсэн | | |
| **Ерөнхий сайдын захирамж** | | | | | | | |
| **Засгийн газрын хуралдааны тэмдэглэл** | | | | | | | |
| 65 | 2021 оны 6 дугаар сарын 8-ны өдөр 34 дүгээр тэмдэглэл<br>2021-06-08<br>Дугаар 2021_34 | 1 | YIII.5.2 . Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хамгаалж, холбогдох хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг эрхэлсэн | Сумын төвд үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудад хяналт тавьж ажилласан. | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | салбар, харьяалах нутаг дэвсгэртээ хангуулах, хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | | | | |
| 66 | 2021 оны 12 дугаар сарын 8-ны өдөр 63 дугаар тэмдэглэл<br>2021-12-08<br>Дугаар 2021_63 | 1 | XY.3.1.3. Орон нутгийн түвшинд өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн өсөлтийн шалтгааныг судалж, холбогдох зохицуулалт, арга хэмжээ авахад санаачилга гарган ажиллахыг бүх аймгийн засаг дарга нарт; | Хугацаа дууссан. | Хугацаа дууссан | | |
| 67 | 2022 оны 2 дугаар сарын 16-ны өдөр 11 дүгээр тэмдэглэл<br>2022-02-16<br>Дугаар 2022_11 | 1 | XIX.6.2. “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан Төрийн бүтээмжийг сайжруулах шинэчлэлтийг хэрэгжүүлэх, төрийн байгууллага цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх шаардлагыг тогтоох, байгууллага, албан тушаалтан иргэнтэй шууд харьцах замаар үйлчилгээ үзүүлдэг байдлыг халах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагад даалгав. | Иргэд татвар, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал, газар өмчлөх, эзэмших, эрх шилжүүлэх, халамжийн мөнгөн тэтгэмжид хамрагдах, малын гарал үүслийн гэрчилгээ авах, бүх төрлийн лавлагаа авах зэрэг үйлчилгээнүүд цахимжсан. Үүнтэй холбогдуулан иргэдэд хөдөө багт 3 удаа 1,2,3-р багт ажиллахдаа болон 6 багийн хурал, хагас бүтэн жилийн мал тооллогын ажлын үеэр мэдээллийг хүргэн ажилласан. Цахим мэдээллийн хэрэгслээр заавар зөвлөгөөг тогтмол оруулж байна. | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 68 | 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл<br>2022-05-11<br>Дугаар 2022_28 | 2 | XX.7. . Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд, тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгов. | Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022.05.01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Монгол Улсын 16 насанд хүрсэн иргэн бүрт тоон гарын үсгийг иргэний хүсэлтээр, оршин суугаа газрын харьяалал харгалзахгүйгээр иргэний үнэмлэхийн санах ой, гар утасны gsign апплекейшнд байршуулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу олгох ажлыг сумын хэмжээнд зохион байгуулж 2025 онд 249 иргэнд тоон гарын үсгийг олгон ажилласан байна. | Хэрэгжсэн | | |
| 69 | 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдөр 33 дугаар тэмдэглэл<br>2022-06-15<br>Дугаар 2022_33 | 1 | XIII.1. . Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, өнөөгийн нөхцөл байдлын талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахтай холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт даалгав: 1.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд болон салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хяналт тавих, | ХХҮГ-н Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал хариуцсан мэргэжилтэн Г.Оюунаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрүүл мэндийн цогц үйлчилгээг хэрхэн үзүүлэх талаар сургалт хийсэн. | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагааг зохих журмын дагуу дэмжиж ажиллах; 1.2. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн хуралдааны 34 дүгээр тэмдэглэлээр өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэх; 1.3. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн харилцаанд тэгш оролцох эрхийг хангах, хамгаалах хүрээнд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэртээ хангуулж, хяналт тавьж ажиллах. | | | | |
| | | 2 | XIII.1.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх нийгмийн халамж, хөгжлийн үйлчилгээг сайжруулахтай холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт даалгав: 4.1. байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч, ажил хөдөлмөр эрхлээгүй байгаа эцэг, эсхүл эх, хууль ёсны асран хамгаалагчийн эрүүл мэндийн даатгалын болон тэтгэврийн даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож улсын төсвөөс төлөх боломжийг судлан саналаа шаардагдах зардлын тооцооллын хамт танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.2. Нийгмийн халамжийн сангаас олгож байгаа хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр болон эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн | Засгийн газрын холбогдох шийдвэрийн хүрээнд сум нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдэд үзүүлэх нийгмийн халамж, эрүүл мэнд, сэргээн засах, хөгжлийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр хууль тогтоомжийн хүрээнд ажиллаж байна. Сумын хэмжээнд байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 8, хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан иргэд 14, эдгээр хүмүүст тэтгэвэр, тэтгэмжийг тогтмол олгож, эрүүл мэндийн үзлэг, эмнэлгийн хяналт, сэргээн засах үйлчилгээнд хамруулан, шаардлагатай тохиолдолд аймаг, төрөлжсөн эмнэлэгт илгээж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эх, асран хамгаалагчдыг мэдээлэл, зөвлөгөөгөөр хангах, сургалт, дэмжлэгт хамруулж ажилласан. | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тэтгэмжийн хэмжээг 288,000 төгрөгөөр үргэлжлүүлэн олгох болон цаашид уг хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх боломжтой эсэхийг судалж, зохих арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа нарт;<br>4.3. хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд шаардлагатай хүний нөөцийн судалгааг хийж, дутагдалтай байгаа мэргэжилтнийг 2022-2023 оны хичээлийн жилээс эхлэн үе шаттайгаар бэлтгэх, сургалтын орчин, материаллаг баазыг бэхжүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт;<br>4.4. хөгжлийн бэрхшээлтэй хүнд эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлдэг эмнэлгийн мэргэжилтний урамшууллыг нэмэгдүүлэх асуудлыг судалж, шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэх талаар холбогдох арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт;<br>4.5. хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчийг хүүхдээ асрах, хөгжүүлэх, дэмжих чиглэлийн богино хугацааны сургалтад хамруулж, энэ чиглэлээр хөдөлмөр эрхлэх, цаашид мэргэжил эзэмшихэд нь холбогдох хууль тогтоомжийн дагуу дэмжлэг үзүүлж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт;<br>4.6. хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийг үнэлэх Үйлдлийн олон улсын ангилал (ICF)-ыг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 4.7. эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчгүй, байнгын асаргаа шаардлагатай сэтгэцийн хүнд хэлбэрийн эмгэгтэй, оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүний асрамжийн үйлчилгээ үзүүлдэг төрөлжсөн асрамжийн газрыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн дэргэд байгуулах асуудлыг судалж, шаардагдах санхүүжилтийг Монгол Улсын 2023 оны төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт;<br>4.8. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн эрүүл мэнд, сэргээн заслын цогц тусламж, үйлчилгээг өргөжүүлж, мэргэжил, арга зүй, хүний нөөц, эм хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжөөр хангах, үйл ажиллагааны чанар, үр дүнг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт;<br>4.9. харьяалах нутаг дэвсгэрийнхээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд эрүүл мэндийн болон нийгмийн сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлдэг, тэдний хөгжлийг дэмжих чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагааны болон санхүүгийн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт,<br>4.10. бага орлоготой, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, гэр бүлийн гишүүнтэй өрхийн орон сууцны хангамж, нөхцөлийг судлан сайжруулах шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт. | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 70 | 2022 оны 8 дугаар сарын 24-ний өдөр 42 дугаар тэмдэглэл<br>2022-08-24<br>Дугаар 2022_42 | 1 | XY.3. Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааны явцын талаар Эрүүл мэндийн сайд С.Энхболд Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэхийг Эрүүл мэндийн сайд С.Энхболдод, уг үйл ажиллагаанд салбарын болон төрийн бүх шатны байгууллагуудын ажилтан, албан хаагчдыг хамруулах, энэ чиглэлд салбарын болон нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг уриалах ажлыг зохион байгуулж зохих арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав. | Сумын хэмжээнд Артерийн гипертензи 1582 хүн хамрагдахаас 1313 хүн хамрагдаж 82,9%, чихрийн шижин 1178 хүн хамрагдахаас 913 хүн хамрагдаж 77,5%, хөхний хорт хавдраас сэргийлэх үзлэг – 627 хүн хамрагдахаас 409 хүн хамрагдаж 65,2%, умайн хүзүүний хорт хавдраас сэргийлэх үзлэг 135 хүн хамрагдахаас 65 хүн хамрагдаж 48,1 %, элэгний хавдараас сэргийлэх 82 хүн хамрагдахаас 80 хүн хамрагдаж 97,5% явж байна. | Хэрэгжсэн | | |
| 71 | 2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 58 дугаар тэмдэглэл<br>2022-12-07<br>Дугаар 2022_58 | 1 | XXI.6.1. Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын удирдлагад үүрэг болгов; | Төрийн цахим шуудан болон ERP системээр албан бичгээ солилцож байна. | Хэрэгжсэн | | |
| 72 | 2023 оны 3 дугаар сарын 1-ний өдөр 10 дугаар тэмдэглэл<br>2023-03-01<br>Дугаар 2023_10 | 1 | XVI.4.2. Мал, амьтны гоц халдварт шүлхий, бог малын мялзан өвчний дэгдэлтийг таслан зогсоох мал эмнэлгийн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг Монгол Улсын Шадар | Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад давхардсан тоогоор 462 өрхийн 33787 үхэр, тугал, хоньны цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад давхардсан тоогоор 575 өрхийн 274470 | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | сайд С.Амарсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт. | толгой хонь хурга, бол малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 539 өрхийн 119506 хурга ишиг хамруулсан. Дунджаар 99 хувийн гүйцэтгэлтэй ванцинжуулсан. | | | |
| 73 | 2023 оны 3 дугаар сарын 07-ний өдөр 11 дүгээр тэмдэглэл<br>2023-03-07<br>Дугаар 2023_11 | 1 | XII.5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон салбарын бодлого, стратегийн төлөвлөгөө, Жендэрийн үндэсний хорооны 2023 оны ээлжит хуралдаанаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллахыг Засгийн газрын гишүүд, яамдын жендэрийн салбар зөвлөл, орон нутгийн салбар хорооны дарга, Жендэрийн үндэсний хорооны гишүүдэд тус тус даалгав. | Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагад ажиллагсдын хүйсийн тэнцвэртэй байдлын тайланг Жендэрийн үндэсний хороонд хугацаанд нь хүргүүлсэн. Сумын ЗДТГ-ын албан хаагчдын хүйсийн хувьд эрэгтэй албан хаагч 45%, эмэгтэй албан хаагч 55%-тай байна.<br>Удирдах түвшний албан тушаалын хувьд: Эрэгтэй 50%, эмэгтэй 50%, төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалтан эрэгтэй 40%, эмэгтэй 60%, улс төрийн албан тушаалтан эрэгтэй 100%, төрийн үйлчилгээний албан тушаалтан эрэгтэй 33%, эмэттэй 66,7%-ийг тус тус эзэлж байна. Сумын Засаг даргын А/19 тоот захирамжаар Сумын Жендэрийн дэд хороог 2025 оны 02 сарын 15-ны өдөр 15 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Жендэрийн дэд хороог хуралдуулж 11 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:<br>“Жендэрийн эрх тэгш байдлыг хангах зорилгоор жил бүр Жендэрийн үндэсний хорооноос “Харилцан хүндэтгэе” аяныг зохион явуулдаг. Тус аяныг сум орон нутгийн иргэдэд сурталчлах зорилгоор Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад “Жендерийн тухай ойлголт, жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, жендерийн хэвшмэл ойлголт”-ын талаар сургалт, сурталчилгаа зохион байгуулсан. | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2 | XII.2.1. Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдалтын явц, амны хөндийн эрүүл мэндийн өнөөгийн байдлын талаар Эрүүл мэндийн сайд С.Чинзориг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1.Хүн амыг эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэх, аймаг, нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа эрүүл мэндийг дэмжих төвүүдийг ходоодны уян дурангийн аппаратаар нэмэлтээр хангахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | Сумын хэмжээнд артерийн гипертензи 1582 хүн хамрагдахаас 1313 хүн хамрагдаж 82,9% ,чихрийн шижин 1178 хүн хамрагдахаас 913 хүн хамрагдаж 77,5% , хөхний хорт хавдраас сэргийлэх үзлэг – 627 хүн хамрагдахаас 409 хүн хамрагдаж 65,2%, умайн хүзүүний хорт хавдраас сэргийлэх үзлэг 135 хүн хамрагдахаас 65 хүн хамрагдаж 48,1 %, элэгний хавдраас сэргийлэх – 82 хүн хамрагдахаас 80 хүн хамрагдаж 97,5% явж байна. Мөн хөдөө багуудаар үе шаттайгаар багийн эмчийн хамт явж урьдчилан сэргийлэх үзлэг хийж эмнэлгийн тусламж шаардлагатай иргэдийн СЭМТ-д хэвтүүлэн эмчилж мөн лавлагаа шатлалд явуулан тусламж үйлчилгээ тэгш хүртээмжтэй байхаар чиглэл болгон ажиллаж байна. | Хэрэгжсэн | | |
| 74 | 2023 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр 17 дугаар тэмдэглэл<br>2023-04-19<br>Дугаар 2023_17 | 1 | XIX.2.3. Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн зөрчлийг арилгуулахаар Хүний эрхийн үндэсний комиссын гишүүнээс гаргасан шаардлага, зөвлөмжийг биелүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд болон бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгов | Шаардлага зөвлөмжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилласан. | Хэрэгжсэн | | |
| 75 | 2023 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр 18 дугаар тэмдэглэл<br>2023-04-26<br>Дугаар 2023_18 | 1 | XIV.7.3. Ой, хээрийн түймэр, болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл, анхааруулгыг олон нийтэд тогтмол хүргэж, бэлэн байдлыг хангуулж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав. | Тухай бүр нь мэдээлэлийг өгч ажилласан. | Хэрэгжсэн | | |
| 76 | 2023 оны 5 дугаар сарын 17-ны өдөр 21 дүгээр тэмдэглэл<br>2023-05-17<br>Дугаар 2023_21 | 1 | XVIII.2.3. Монгол Улсын хөгжлийн бодлого, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хүний хөгжил, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд эерэг үр нөлөөтэй байхад чиглүүлэн бодитой, үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав. | Монгол Улсын хөгжлийн бодлого, хууль тогтоомж, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангах хүрээнд хүний хөгжил, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд эерэг үр нөлөө үзүүлэх зорилгоор бодитой, үр дүнтэй хэрэгжүүлэх чиглэлээр холбогдох байгууллагууд арга хэмжээ авч | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ажиллалаа.<br><br>Хэрэгжилтийн хүрээнд салбар дундын уялдаа холбоог сайжруулж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг төлөвлөлт, тайлагнал, хяналт-шинжилгээ, үнэлгээтэй уялдуулан хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт сайжирч, нийгэм, эдийн засаг, хүний хөгжил, байгаль орчны чиглэлээр бодит ахиц гарсан.<br><br>Цаашид бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн үр нөлөөг нэмэгдүүлэх, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх, хэрэгжилтийн явцад гарч буй хүндрэл, эрсдэлийг цаг тухайд нь тодорхойлон шийдвэрлэхэд анхаарч ажиллана. | | | |
| 77 | 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр 23 дугаар тэмдэглэл<br>2023-05-31<br>Дугаар 2023_23 | 1 | XXII.2. “Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох мэдээлэл хариуцагч байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгов:<br>1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллийг өөрийн байгууллагын цахим хуудаст, шаардлагатай мэдээллийг нэгдсэн систем (shilen.gov.mn)-д байршуулж, тухай бүр шинэчилж ажиллах;<br>2. Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-д мэдээллийг шууд холбох боломжтой байдлаар өөрийн байгууллагын системийн бэлэн байдлыг хангах; | Shilen.gov.mn системд Засгийн газрын 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 352 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам"-ын дагуу байршуулж, 2024 оны 4-р улирлын дүгнэлт 57,12%, 2025 оны 1-р улирлын дүгнэлт 60,07%-аар үнэлэгдсэн. 2025 оны жилийн эцэс дүгнэгдээгүй байна. | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 3. Мэдээллийн сан, системийн хэвийн үйл ажиллагаа болон мэдээллийн үнэн зөв, алдаагүй байдлыг бүрэн хариуцах. | | | | |
| 78 | 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдөр 40 дүгээр тэмдэглэл<br>2023-10-04<br>Дугаар 2023_40 | 4 | 2.28. Аймаг, сумын баяр наадам тэмдэглэх зардлыг нэмэгдүүлэх боломжийг судлан, саналаа холбогдох төрийн захиргааны төв байгууллагад танилцуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | Хугацаа дууссан. | Хугацаа дууссан | | |
| 79 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны 15 дугаар тэмдэглэл<br>2024-04-17<br>Дугаар 2024_15 | 1 | 20.11.1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд байнга ил тод, нээлттэй байлгахаар заасан мэдээллийг “Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)”-д байршуулах ажлыг хариуцсан салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, мэдээллийг тухай бүр шинэчилж ажиллахыг төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой байгууллагуудын удирдлага, аймаг, нийслэлийн Засагдарга нарт; (Шил” ажиллагааны хэрэгжилтийн талаар) | Shilen.gov.mn системд Засгийн газрын 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 352 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам"-ын дагуу байршуулж, 2024 оны 4-р улирлын дүгнэлт 57,12%, 2025 оны 1-р улирлын дүгнэлт 60,07%-аар үнэлэгдсэн. 2025 оны жилийн эцэс дүгнэгдээгүй байна. | Хэрэгжсэн | | |
| 80 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 22 дугаар тэмдэглэл<br>2024-06-06<br>Дугаар 2024_22 | 1 | 37.1.1. “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлж, малчдад зөвлөн туслах үүрэг бүхий багийг орон нутагт үргэлжлүүлэн ажиллуулж, холбогдох албан хаагчдын албан томилолтын болон замын зардал, тээврийн хэрэгслийг шуурхай шийдвэрлэх арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, агентлагийн дарга, төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга (захирал) нарт | Малчид хоршооны үйл ажиллагаанд итгэх итгэл нэмэгдэж, "Шинэ-Хоршоо" хөдөлгөөнд шинээр 23 өрх нэгдсэн. Тус шинээр байгуулагдсан хоршоодын нарийвчилсан судалгааг гарган мэдээллийн бааз үүсгэсэн. Хоршооны нийт гишүүдийн тоо 430-аар нэмэгдсэн. Шинэ хоршоодын мал аж ахуй, түүхий эд боловсруулах чиглэлээр ихэнх хувийг эзэлж байна. 47 шинэ хоршоонд хоршоо үүсгэн байгуулах тухай хурлын талаарх мэдээллийг хүргэж 5 хоршооны үүсгэн байгуулах бүх гишүүдийн хуралд биечлэн оролцсон. Хоршооны санхүүгийн үйл ажиллагааг хэрхэн бүртгэх талаар зааварчилгаа өгсөн. Хоршооны татварын хууль, боломжит хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаар мэдээлэл өгсөн. “Хоршооны тухай” хуулийн 2 видео танилцуулга, 2 төрлийн гарын авлагыг бэлтгэн цахимд | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | байршуулсан. Хаан банканд 7 хоршооны 15 малчин 465.0 сая.төгрөг, Төрийн банканд 13 хоршооны 45 малчин 1,710.0 сая.төгрөгийн зээлийн мал худалдан авах, байр саравч барих, сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлийн төслийн зээл авсан. Батлан даалтын сангаас Хаан банкаар зээл авсан 3 хоршооны 8 малчин 137.05 сая.төгрөг, Төрийн банкнаас 8 хоршооны 620.14 сая.төгрөгийн батлан даалтын санхүүжилт авсан. Олон улсын Хоршооллын өдөрт 1 жишиг хоршоог үзэсгэлэн худалдаанд оролцуулж туршлага судлуулав. Тус үзэсгэлэнгийн үеэр 400.00 мянган төгрөгийн борлуулалт хийгдсэн байна. | | | |
| 81 | Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдааны 31 дүгээр тэмдэглэл<br>2024-09-04<br>Дугаар 2024_31 | 1 | 31.9.6. 2/ Төрийн байгууллагын “gov.mn” нэгдсэн цахим хуудаст мэдээллийг байршуулах, тухай бүр шинэчлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт | Байгууллага бүр 1 албан хаагчид ажил үүргийг хавсран гүйцэтгүүлж мэдээ, мэдээллийг тухай бүр байршуулан ажиллаж байна. | Хэрэгжсэн | | |
| 82 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдааны 32 дугаар тэмдэглэл<br>2024-09-11<br>Дугаар 2024_32 | 1 | 32.6.2.. 2.1. Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 50 дугаар тэмдэглэлээр өгсөн даалгаврыг хэрэгжүүлж, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгүй сумдын төлөвлөгөөг боловсруулж, батлуулах ажлыг эрчимжүүлж, шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусган шийдвэрлүүлэхийг холбогдох аймаг, сумын Засаг дарга нарт, төлөвлөгөөний харилцан уялдааг зохицуулж, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурьд | Сумын ерөнхий боловсруулах тендерийг 5 удаа зарласан боловч гүйцэтгэгч материал ирүүлээгүй. | Хэрэгжээгүй | | |
| | | 1 | 14.7.2.. Газрын эрхийн давхцалтай 6206 зөрчлийг арилгах, тусгай хамгаалалттай | Энэ онд ашигт малтмалын зориулалтаар төлөвлөгөөнд тусгагдсан газар байхгүй тул олголт хийгдээгүй байна. | Хэрэгжээгүй | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 83 | Газрын эрхийн давхцалтай 6206 зөрчлийг арилгах<br>2024-10-02<br>Дугаар 35 | | газар нутагт олгогдсон 4953 нэгж талбар газрын эрх болон уул уурхай, ашигт малтмалын зориулалтаар олгогдсон 447 нэгж талбар газрын эрхийг баталгаажуулах ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах арга хэмжээ авахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгав; | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 84 | 39.29.11.3. Энэ тэмдэглэлийн 2.1, 2.2, 2.3 дахь хэсэгт зааснаас гадна захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй байгаа өөрийн салбарын бусад шийдвэрийг дараах чиглэлээр хянан үзэж, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бичгээр хариу мэдэгдэхийг бүх шатны захиргааны байгууллагын удирдлагад даалгав:<br>2024-11-13<br>Дугаар 39 | 3 | 39.29.11.1.2. эрхэлсэн асуудал, чиг үүргийнхээ хүрээнд захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрүүдийг хууль тогтоомжийн өөрчлөлттэй уялдуулан дагаж мөрдөхгүй болсон, эрх зүйн үйлчлэлийн хугацаа дууссан, хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн, Хууль зүй, дотоод хэргийн сайдаас хүчингүй болгох дүгнэлт гаргаж хүргүүлсэн боловч хүчингүй болгоогүй, мөн хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын хүрээнд хуульд нийцүүлэхээр ажиллаж байгаа талаар хариу ирүүлсэн шийдвэрүүдийг дүгнэлтийн дагуу хүчингүй болгон, хуульд нийцүүлэх арга хэмжээг авч, 2025 оны 1 дүгээр улиралд багтаан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэх (1.13Захиргааны хэм хэмжээний актад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн үр дүнгийн тайлан, цаашид авах арга хэмжээний талаар танилцуулсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн болон бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгож, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газрын бус бие даасан агентлаг болон эрх шилжүүлэн авсан нийтийн эрх зүйн этгээдийн эрх бүхий албан тушаалтнуудад зөвлөв) | Хамааралгүй. | Хамааралгүй | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 4 | 39.29.11.1.3. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хийсэн судалгаа, түүнчлэн өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дагаж мөрдөж байгаа хуулиудаас тусгайлан эрх олгосон заалтын судалгааг гаргаж, батлах зохицуулалттай боловч батлаагүй, баталсан боловч захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэлгүй даган мөрдөж байгаа шийдвэрүүдийг хянан үзэж, тэдгээрийг батлах, бүртгүүлэх арга хэмжээг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан авч хэрэгжүүлэх;(1.4. цаашид нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрт тогтмол дүн шинжилгээ хийж, шинээр батлагдсан хууль тогтоомжид нийцүүлэн холбогдох шийдвэрт тухай бүр нь нэмэлт, өөрчлөлт оруулж, санд хөдөлгөөн хийлгэх ажлыг хэвшүүлэх; 1.5. шийдвэрийг баталснаас хойш ажлын 5 өдрийн дотор хянуулж, бүртгүүлэх хугацааг баримталж ажиллах; 1.6. Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулж, бүртгүүлсэн шийдвэрүүдээр салбарын сан байгуулж, иргэдэд үйлчлэх чиг үүргээ биелүүлж ажиллах; | Шинээр гарсан Малчны тухай хууль, Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, 2020 онд шинэчилсэн найруулсан Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, 2024 онд Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, 2025 онд нэмэлт өөрчлөлт орсон Төсвийн тухай хууль, Эрүүгийн хууль, Төрийн албаны тухай хууль, 2025 онд батлагдсан Ерөнхий лөгчийн зарлиг 3, Засгийн газрын тогтоол 41, Монгол Улсын Их Хурлын тогтоол 10, Сайдын тушаал 15, Засгийн газрын агентлагын даргын тушаал 20 албан тушаалтнуудад шилжүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. | Хэрэгжсэн | | |
| | | 5 | 39.29.11.1.7. Захиргааны ерөнхий хуулийг үйл ажиллагаандаа дагаж мөрдөн хэвшүүлэх, цаашид уг хуультай холбоотой зөрчил гаргахгүй байх, гаргасан тохиолдолд холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцож ажиллах | Засаг даргын Тамгын газар нь Захиргааны ерөнхий хуулийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж, захиргааны үйл ажиллагааг хуульд нийцүүлэн явуулахад анхаарч ажиллалаа.<br><br>Уг хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд албан хаагчдад Захиргааны ерөнхий хуулийн үндсэн зарчим, шаардлагыг таниулж, өдөр тутмын үйл ажиллагаанд хэвшүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Мөн захиргааны шийдвэр гаргах, хэрэгжилтийг хангах үйл ажиллагаанд хууль зөрчих эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд анхаарч ажилласан. | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Үүний үр дүнд Захиргааны ерөнхий хуультай холбоотой зөрчил дутагдал гарахгүй байх нөхцөл бүрдэж, цаашид зөрчил гаргасан тохиолдолд холбогдох албан тушаалтанд хуульд заасан хариуцлага тооцож ажиллах тогтолцоо тодорхой боллоо.<br><br>Цаашид Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, албан хаагчдын хууль зүйн мэдлэгийг тасралтгүй дээшлүүлэн ажиллана. | | | |
| 85 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдааны 40 дүгээр тэмдэглэл<br>2024-11-20<br>Дугаар 40 | 1 | 40.19.7.2. Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа аймаг, сум, нийслэл, дүүргийн хилийн цэсийг тогтоосон Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлиг, Улсын Их Хурлын тогтоолыг сахин мөрдөж, тэдгээрээс зөрүүтэй газар зүйн нэр, зургийг үндэслэн аливаа хилийн цэстэй холбоотой маргаан үүсгэхгүй байх талаар онцгой анхаарч ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгов. | Аймаг сумдын хилийн цэстэй холбоотой маргаан малчдын дунд гараагүй байна. | Хэрэгжээгүй | | |
| | | 2 | 40.19.5.3. “Өвлийн идэш” арга хэмжээнд малчдын хоршоодын оролцоог хангахад дэмжпэг үзүүлж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.” гэжээ. | Малчдыг мэдээ мэдээлэлтэй хангаж үйлдвэрүүдтэй холбож зуулчилсан. | Хэрэгжсэн | | |
| 86 | Нийслэлийн хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллагыг өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх<br>2024-12-30<br>Дугаар 47 | 1 | 47.8.1.2. Нийслэлийн хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллагыг өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан шинэ жилийн баяр, амралтын өдрүүдэд бэлэн байдалд ажиллахыг Засгийн газрын гишүүд, нийслэлийн бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгов. | Нийслэлийн хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллагыг өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан гарсан Засгийн газрын шийдвэр, чиглэлийн дагуу Таргат сумын Засаг даргын Тамгын газар нь шинэ жилийн баяр, амралтын өдрүүдийн хугацаанд хариуцлагатай жижүүрийн хуваарь гарган ажиллаа.<br><br>Уг үүргийн хүрээнд жижүүрийн хуваарь | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | баталж, хариуцлагатай албан тушаалтнуудыг томилон, иргэдэд төрийн үйлчилгээ тасалдуулахгүй байх, болзошгүй эрсдэл, нөхцөл байдалд шуурхай арга хэмжээ авах зохион байгуулалтыг хангаж ажиллав.<br><br>Үүний үр дүнд шинэ жилийн баяр, амралтын өдрүүдэд сумын хэмжээнд төрийн байгууллагын үйл ажиллагаа, иргэдийн аюулгүй байдал, нийтийн хэв журам тогтвортой хангагдлаа. | | | |
| 87 | Хот байгуулалтын тухай хууль тогтоомжид заасны дагуу<br>2025-03-06<br>Дугаар 11 | 1 | 11.6.2. Хот байгуулалтын тухай хууль тогтоомжид заасны дагуу харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээний хот, тосгон, суурин газруудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон барилгажилтын төслийг боловсруулан, тус тус батлуулж, хэрэгжүүлэх ажлыг яаралтай зохион байгуулахыг аймгийн Засаг дарга нарт даалгав.” гэжээ.(1.Монгол Улсын иргэнд 2025 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай асуудлыг хэлэлцээд тогтоол гаргахаар тогтов. | Хэрэгжээгүй. | Хэрэгжээгүй | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 88 | Харьяа хот, тосгон, бусад суурины газрын эдэлбэр газрын хэмжээ 2025-03-19 Дугаар 13 | 2 | 13.23.3.1.1.2.. Бэлчээрийн газар ашиглалт, түүний даацыг тохируулах, өнжөөн сэлгэх, хүчтэй элэгдэл, эвдрэлд өртсөн газрыг нөхөн сэргээх, хот, суурин газрын хөрсний бохирдлыг бууруулах арга хэмжээг жил бүрийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийг хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;(1 .Дараах арга хэмжээг шуурхай хэрэгжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав:) | 2025 оны Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар тогтоох ажлын хүрээнд 2016 оноос хойш сумын хэмжээнд нийт 6 багт байнга ашиглагдах 19 цэгт Хээрийн судалгаа, мэдээлэл цуглуулах ажлын үе шатанд бэлчээрийн төлөв байдал, түүний өөрчлөлтийг газар дээр нь судлаж үнэлэн Бэлчээрийн даацын хувьд нийт мал бэлчээрлэх хоногийн тоог 150 хоногоор тооцож -12376.3005 толгой малаар хэтэрсэн байна. | Хэрэгжсэн | | |
| | | 3 | 13.23.3.1.1.3.. Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа болон Газрын тухай хуульд заасны дагуу гэр бүлийн хамтын хэрэгцээнд зориулан иргэнд үнэ төлбөргүй газар эзэмшүүлэх, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар малчдын хоршоонд 5 га хүртэлх газрыг төсөл сонгон шалгаруулалтаар олгох арга хэмжээг цахим системээр зохион байгуулж, шийдвэрлэж хэвших, иргэд, олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй мэдээлэл өгөх;(1.Дараах арга хэмжээг шуурхай хэрэгжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав: | Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан газар байхгүй. Сумын хөгжлийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийгдээгүйтэй холбоотой. | Хэрэгжээгүй | | |
| | | 4 | 13.23.3.1.1.4.. Уул уурхай, ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй газрын эрхийг баталгаажуулах ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах.(1.Дараах арга хэмжээг шуурхай хэрэгжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав:) | Уул уурхай болон түгээмэл тархацтай ашигт малтмал эрхэлдэг 2 компанийн зөвшөөрлийг олгоогүй байна. | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 89 | Зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох хүсэлт<br>2025-03-26<br>Дугаар 14 | 1 | 14.16.7.2.. Зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох хүсэлтийг хүлээн авах, магадлан шалгах, шийдвэр гаргахад төрийн мэдээлэл солилцооны “Хур” систем, цахим төлбөрийн баримтын системийг ашиглах, шийдвэрийн талаар мэдэгдлийг “И-Монгол” цахим системээр дамжуулан иргэнд хүргэх нөхцөлийг бүрдүүлж, тусгай зөвшөөрлийн цахим систем (Liicense), Төрийн үйлчилгээний “e-business.mn” системийг ашиглах арга хэмжээг 2025 оны II улиралд багтаан хэрэгжүүлэхийг Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Гаалийн ерөнхий газар (Р.Отгонжаргал), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | Сумын операторын үйлчилгээгээр 11 сарын байдлаар 582 лавлагаа, мэдээлэл, 19 иргэнд И-монголиа суулгаж, нээж өгсөн. гаргаж өгсөн. Хурдан киоск үйлчилгээний машиныг ЗДТгазарт суурьлуулсан. 11 сарын байдлаар 164 иргэн лавлагаа мэдээлэл авсан үзүүлэлттэй байгаа. 5 сарын 15 - 6 сарын 10 хүртэл интернэтээс шалтгаалан ажиллаагүй. Үйлчилгээний нэр Нийт Иргэний үнэмлэхийн лавлагаа 108 Иргэний оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн лавлагаа 107 Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт 63 Мал тооллогын лавлагаа 40 Шүүхийн шийдвэрээр бусдад төлбөргүй эсэх тодорхойлолт (Иргэн) 29 Үл хөдлөх эд хөрөнгө өмчилж байгаа болон шилжүүлсэн тухай лавлагаа 21 Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт 18 Эрүүл мэндийн даатгалын төлөлт шалгах 14 Малчны тодорхойлолт 13 Үл хөдлөх хөрөнгийн лавлагаа 12 | Хэрэгжсэн | | |
| 90 | Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулах<br>2025-04-02<br>Дугаар 15 | 1 | 15.13.4.2.. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулах хүрээнд жилийн эцсийн тайлан, мэдээнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж, чиглэл хүргүүлж, хэрэгжилт, үр дүнг тооцон ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.” | Энэ онд Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол, хүсэлт, санал, мэдэгдэл Засаг даргын Тамгын газар болон төсөвт байгууллага Эрүүл мэндийн төв, Соёлын төвд хандаж нийт 31 өргөдөл, гомдол, хүсэлт, санал, мэдэгдэл хүлээн авсан байна. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг байгууллагад хандаж ирүүлсэн сувгаар нь авч үзвэл: албан бичгээр 20, цахимаар 3, өөрийн биеэр биечлэн 8 өргөдөл ирүүлсэн. Мөн ирүүлсэн нийт 31 өргөдөл, хүсэлт, гомдол, саналыг төрөл тус бүрээр нь авч үзвэл: өргөдөл буюу хүсэлт нь 24 буюу 77,4 хувь, гомдол нь 3 | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | буюу 11,1 хувь мэдэгдэл нь 4 буюу 14,8 хувийн эзэлж байна. Шийдвэрлэсэн байдлаар нь үзвэл: 31 өргөдөл, гомдол, мэдэгдэлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариу хүргүүлсэн байна. | | | |
| 91 | Улаанбурхан өвчний тандалт, дархлаажуулалт, хариу арга хэмжээ<br>2025-04-23<br>Дугаар 19 | 1 | 19.24.5.2.. Улаанбурхан өвчний тандалт, дархлаажуулалт, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангаж, бүх шатлалын эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжлийн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав | Зорилтод насны хүүхдүүдэд 3 тунт вакцинд бүрэн хамрагдуулах ажлын хүрээнд 2006 оноос өмнөх хүүхдүүдэд нөхөн шивэлт хийж 2006 оноос хойш хүүхдүүдэд шүүлт хийж дархлаажуулалт бүрэн хамрагдаагүй хүүхдүүдэд нөхөн дархлаажуулалт хийж байна. | Хэрэгжсэн | | |
| 92 | 2024 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнд<br>2025-05-28<br>Дугаар 25 | 1 | 2024 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнд үндэслэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь өөрийн үйл ажиллагаанд дүгнэлт хийж, хэрэгжээгүй болон хэрэгжилт хангалтгүй байгаа арга хэмжээг эрчимжүүлэх ажлыг төлөвлөн хэрэгжүүлж, дүнг 2025 оны 4 дүгээр улирал багтаан Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт ирүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | Хяналт-шинжилгээ үнэлгээнд үндэслэн байгууллагын мэдээллийг ил тод мэдээллэх чиглэлээр ажлуудыг хийсэн. Сумын цахим сайтад байгууллагын танилцуулга, зорилго зорилтоос эхлүүлэн төрийн албан хаагчдын мэдээлэл, гүйцэтгэлийн тайлан төлөвлөгөө, үнэлгээ, худалдан авах ажиллааны тайлан мэдээлэл зэргийг тогтмол тавьж иргэдэд мэдээллээ | Хэрэгжсэн | | |
| 93 | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 26 дугаар хуралдааны тэмдэглэл<br>2025-06-04<br>Дугаар Дугаар 2025_26 | 1 | 26.27.6.2.. Улаанбурхан өвчний тандалт, дархлаажуулалт, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангахад шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэх, үндэсний товлолын дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн бүх шатлалын байгууллагад дэмжлэг үзүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | | | | |
| 94 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29.1 дэх хэсгийн хэрэгжилтийн талаар<br>2025-08-06<br>Дугаар 11 | 1 | 9.7. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29.1 дэх хэсгийн хэрэгжилтийн талаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг төрийн 6 байгууллагын дарга нарт мэдээлэл өгч, мэдээ мэдээллийг тухай бүр цахим сайтуудад нээлттэй тавьж, шилэн дансны мэдээллийг тогтмол хянаж, бүрэн | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулахад цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар зөвлөмж, дүгнэлт гаргуулж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, мэдээлэл хариуцагч байгууллагын удирдлагуудад даалгав. | байршуулахад анхааран ажиллаж байна. | | | |
| **Засгийн газрын албан даалгавар** | | | | | | | |
| 95 | Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг сурталчлан таниулах тухай<br>2022-07-05<br>Дугаар 2022_6 | 1 | 1.1. "Алсын хараа-2050", "Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын зорилго, зорилт, үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар харъяа байгууллагын албан хаагчдад сургалт зохион байгуулах;<br>1.2. "Алсын хараа-2050", "Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хэрэгжилтийн явцын талаар иргэд, олон нийтэд таниулах, сурталчлах ажлыг салбарынхаа хэмжээнд зохион байгуулах; | Бодлогын баримт бичгүүдийн дагуу тухайн жилд хийх ажилд төлөвлөн ажиллаж байна. Суманд 22 км авто зам тавигдах зураг төсөв батлагдаж ирэх жилээр зам тавигдахаар боллоо. Шинэ төгсөлтийн нарийн мэргэжлийн 2 эмчтэйорон нутгаас нийгмийн баталгааг нь хангахад дэмжлэг үзүүлж гэрээ байгуулан ажиллуулж байна. Үйлдвэржилтийн парк барих төслийн зураг төсвийг хийлгэж бэлэн болголоо. Бизнес эрхлэх иргэдийг дэмжих ажлын нэмэгдүүлэх зорилгоор хуучин Тамгын газрын барилгат 60,0 сая төгрөгийн засвар тохижилт хийлээ. Сумын төвийн иргэдийн ундны усны эрүүл ахуйг сайжруулж шинээр худаг гарган ионжуулагч тавьсан. | Хэрэгжсэн | | |
| 96 | Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай<br>2025-06-18<br>Дугаар 2025_01 | 1 | 1.1.. Шинжлэх ухааны судалгаа, нотолгоонд суурилсан шийдвэр гаргаж, ард иргэдээ сонсон, итгэл, хүлээлт, шаардлагад нь нийцэж ажиллах; | Засаг даргын Тамгын газар нь шинжлэх ухааны судалгаа, бодит мэдээлэл, нотолгоонд тулгуурлан шийдвэр гаргах зарчмыг үйл ажиллагаандаа баримталж, бодлого, шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэх үйл явцад иргэдийн санал, хүсэлт, хүлээлтийг харгалзан ажиллалаа.<br><br>Энэхүү зорилгын хүрээнд судалгаа, дүн | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | шинжилгээний үр дүнг удирдлагын шийдвэр гаргалтад ашиглаж, иргэдтэй хийх уулзалт, хэлэлцүүлэг, санал авах сувгийг идэвхжүүлэн, олон нийтийн оролцоог хангах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.<br><br>Үүний үр дүнд гаргасан шийдвэрийн бодит байдал, хэрэгжилт сайжирч, иргэдийн итгэл, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх нөхцөл бүрдлээ. | | | |
| | | 2 | 1.2.. Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг ханган, салбарын удирдлагын манлайллыг мэргэжлийн түвшинд хариуцлагатай хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж ажиллах; | Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажиллах талаар албан хаагчдадаа танилцуулсан. Хагас жилээр ажлыг дүгнэж, ажил үүрэг хангалтгүй байгаа албан хаагч нарт ажил үүргээ хариуцлагатай хийх талаар албан мэдэгдэл хүргүүлсэн. Ажил үүрэгтээ мэргэжлийн түвшинд хариуцлагатай мөрдөн ажиллаж байна. | Хэрэгжсэн | | |
| | | 3 | 1.3.. Яам, харьяа байгууллага, салбарын хэмжээнд сахилга, хариуцлагыг өндөржүүлж, бүх шатанд төсвийн хэмнэлтийн горимыг сахин, үр ашиггүй зардлыг танах, төрийн байгууллагын бүтэц, чиг үүргийн давхардлыг арилгаж, орон тоог үе шаттай цөөлөх; | Хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажилласан. | Хэрэгжсэн | | |
| | | 4 | 1.5.. Улс төрөөс ангид, чадахуйн зарчимд суурилсан, хүртээмжтэй, шуурхай, хариуцлагатай төрийн албыг бэхжүүлж, хүнд суртал, шат дамжлагыг эрс бууруулах бодитой ажлыг зохион байгуулан, тодорхой ахиц гаргаж, үр дүнг тайлагнах; | Цахим үйлчилгээг иргэдэд хүргэхэд нэн шаардлагатай байгаа сүлжээний асуудлыг шийдвэрлүүлэхээр юнител ХХК-тай гэрээ байгуулан ирэх онд нэг сүлжээ нэмж байршуулахаар төлөвлөөд байна. Иргэдэд цахим үйлчилгээ авах зөөвөр зөвлөгөөг хөдөө багуудын хурал дээр болон хагас бүтэн жилийн мал тооллогын ажлын үеэр, хөдөөд ажиллахадаа байнга зөвлөгөө өгч мэдээллэн ажиллаж байна. | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 7 | 2.1.. Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал болон бусад хууль тогтоомжийг чанд мөрдөж, зөрчсөн үйлдэл гаргахгүй байх; | Засаг даргын Тамгын газар нь Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал болон бусад хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа чанд мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллалаа.<br><br>Уг баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангах хүрээнд албан хаагчдад хууль, бодлогын баримт бичгийн талаарх ойлголт, хариуцлагыг нэмэгдүүлж, өдөр тутмын үйл ажиллагаанд зөрчил гаргахгүй байх, хуульд нийцсэн шийдвэр гаргах зарчмыг баримталсан.<br><br>Үүний үр дүнд холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн үйлдэл, зөрчил дутагдал гараагүй бөгөөд цаашид хууль дээдлэх зарчмыг сахин мөрдөж, хяналт, хариуцлагын тогтолцоог тогтвортой хэрэгжүүлэн ажиллах нөхцөл бүрдлээ. | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 9 | 2.3.. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгах үүргийн биелэлтэд харьяа байгууллага, хуулийн этгээдийн хэмжээнд тогтмол хяналт тавьж, зөрчсөн этгээдэд хариуцлага тооцох; | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу сумын хэмжээнд төрийн болон нутгийн захиргааны байгууллага, харьяа байгууллага, хуулийн этгээдүүдийн мэдээллийг ил тод, нээлттэй байлгах үүргийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллалаа.<br><br>Уг хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд мэдээлэл нийтлэх, шинэчлэх, иргэдэд хүртээмжтэй болгох чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг авч, холбогдох байгууллагуудад чиглэл өгч, хэрэгжилтэд дотоод хяналт хийсэн. Мөн хууль зөрчсөн тохиолдолд холбогдох этгээдэд хариуцлага тооцох тогтолцоог мөрдлөг болгон ажиллав.<br><br>Үүний үр дүнд сумын хэмжээнд мэдээллийн ил тод байдал сайжирч, хууль зөрчсөн зөрчил дутагдал буурах нөхцөл бүрдлээ. | Хэрэгжсэн | | |
| | | 10 | 2.4.. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллаж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, хүнд суртал, шударга бус байдалтай тууштай тэмцэх, таслан зогсоох, албан тушаал, эрх мэдлээ | Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим, Төрийн албаны тухай хуулийн "Албаны эрх мэдлээ хэтрүүлэх", "Хуульд нийцээгүй шийдвэр гаргахыг хориглосон" хэм хэмжээ, Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйл "... албан үүргээ | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | урвуулан ашиглахгүй байх, төрийн байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг идэвхжүүлэх; | гүйцэтгэхдээ хууль бусаар аливаа хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, олгохоор амлах, бусдын эрхийг хязгаарлах", "..... албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх", Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх тухай хуулиар тогтоосон "Албан тушаалтан албаны бүрэн эрхээ хувийн зорилгод ашиглахгүй байх" зэрэг хуулийн зохицуулалтыг төрийн байгууллагууд өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгох, Байгууллагын дарга, эрхлэгч нар, ИТХ-ын төлөөлөгчид, төрийн албан хаагчдад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор "Хүний эрхэд суурилсан төрийн үйлчилгээ, Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт"-ыг зохион байгууллаа.<br>Ёс зүйн хууль тогтоомжийн талаарх мэдлэг, ойлголтыг иргэд олон нийт болон орон нутгийн байгууллагуудад түгээн сурталчилж, байгууллагын ажилтнуудын ёс зүйг сахих хандлагыг төлөвшүүлэх, ил тод, хариуцлагатай байдлыг бэхжүүлэх зорилгоор “Ёс зүйтэй төрийн алба” уриан дор зохион байгуулагдаж буй Ёс зүйн хууль тогтоомж сурталчлах 14 хоногийн аяны хүрээнд Тарагт сумын Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн дэд хороо, Өвөрхангай аймгийн Насан туршийн суралцахуйн төв хамтран "Төрийн албан хаагчийн ёс зүй ба Эерэг харилцаа, хандлага" сургалтыг зохион байгууллаа. Сургалтад 50 гаруй албан хаагч оролцлоо. | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 12 | 2.6.. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад томилолтыг хязгаарлаж, тансаглалыг таслан зогсоох талаар харьяа байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг өгч, үр дүнг тооцож ажиллах. | Хэмнэлтийн тухай хуулийн мөрдөн ажиллаж байна. | Хэрэгжсэн | | |
| | | 13 | 3.2.. Ерөнхий сайдын өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг хангаж, үр дүнг тухай бүр тайлагнах, биелүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцох; | Тухай бүр нь хэрэгжүүлэн ажилласан байна. | Хэрэгжсэн | | |
| | | 14 | 3.3.. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн, танилцуулсан, эрхлэх ажлын хүрээнд хамаарах асуудлыг бүрэн хариуцаж, гарсан шийдвэр, үр дүнгийн талаар олон нийтэд үнэн зөв, бодитой мэдээлэл өгч байх. | Тухай бүр нь мэдээллийг хүргэн ажилласан байна. | Хэрэгжсэн | | |
| 97 | Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах тухай албан даалгавар<br>2025-07-08<br>Дугаар 2025_03 | 1 | 1.1. Улс төрөөс ангид, чадахуйн зарчимд суурилсан хүртээмжтэй, шуурхай, хариуцлагатай төрийн үйлчилгээг хүргэх, хүнд суртал, шат дамжлагыг бууруулах үр дүнтэй ажлыг зохион байгуулан, ажлын бүтээмжийг нэмэгдүүлж, цахим шилжилтийг эрчимжүүлэх | Цахим үйлчилгээг иргэдэд хүргэхэд нэн шаардлагатай байгаа сүлжээний асуудлыг шийдвэрлүүлэхээр юнител ХХК-тай гэрээ байгуулан ирэх онд нэг сүлжээ нэмж байршуулахаар төлөвлөөд байна. Иргэдэд цахим үйлчилгээ авах зөөвөр зөвлөгөөг хөдөө багуудын хурал дээр болон хагас бүтэн жилийн мал тооллогын ажлын үеэр, хөдөөд ажиллахдаа байнга зөвлөгөө өгч мэдээллэн ажиллаж байна. | Хэрэгжсэн | | |
| | | 2 | 1.2. харьяа байгууллага, хуулийн этгээдийн хэмжээнд сахилга, хариуцлагыг чангатгаж, төсвийн үр ашиггүй зардлыг танан, хэмнэлтийн горимыг чанд мөрдөх, бүтэц, чиг үүргийн давхардлыг арилган, орон тоог үе шаттай цөөлөх | Хэмнэлтийн тухай хуулийг мөрдлөг болгон ажиллаж байна. | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 4 | 1.4. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг ханган, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх | Төрийн албан хаагчдад ёс зүйн хэм хэмжээг танилцуулж, шторк бэлтгэж иргэдэд түгээсэн. | Хэрэгжсэн | | |
| | | 6 | 1.6. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад томилолтыг хязгаарлаж, төсвийн хөрөнгөөр олон нийтийн арга хэмжээг зохион байгуулахгүй байх талаар харьяа байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг өгч, үр дүнг тооцож ажиллах | Хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажилласан. | Хэрэгжсэн | | |
| | | 8 | 2.2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгах үүргийн биелэлтэд харьяа байгууллага, хуулийн этгээдийн хэмжээнд тогтмол хяналт тавьж, зөрчсөн этгээдэд хариуцлага тооцож ажиллах | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу төрийн байгууллагуудад мэдээллийг хүргэж өөрсдийн цахим хуудас болон шилэн дансны мэдээллийг тогтмол байршуулж иргэдэд мэдээллэхэд хяналт тавин ажиллаж байна. | Хэрэгжсэн | | |
| | | 9 | 2.3. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллаж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, хүнд суртал, шударга бус байдалтай тууштай тэмцэх, таслан зогсоох, албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглахгүй байх, бүх шатанд Ёс зүйн дэд хороодыг байгуулж үйл ажиллагааг нь идэвхжүүлэх | Авлигын талаарх мэдээлэл өгөх утсыг иргэдэд сурталчилснаар иргэд мэдээллийг тухай бүр өгч шалгуулж болох талаар мэдээлэлтэй болсон байна. Удирдах албан тушаалтнууд болон холбогдох албан хаагч нарт ашиг сонирхол үүсч болох эрсдэлтэй ажил, үйлчилгээнд зөвлөгөө өгч, хэрэв үүссэн бол хэрхэн мэдээллэж ажиллах талаар сургалтыг 2 удаа 23 албан хаагчид, мэдээлэл, зөвлөгөөг давхардсан тоогоор 17 албан тушаалтанд өгөв. Байгууллагын цахим сайтаар дамжуулан байгууллагын албан хаагчдын танилцуулгыг хийж, байгууллагын хийсэн ажил, үйлчилгээг тухай бүр нийтэд ил тод мэдээллэж байна. | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хуулийн үйлчлэлд хамаарч буй албан тушаалтны сул орон тоо гарсан бүрийд сонгон шалгаруулалтыг хуулийн дагуу зохион байгуулж, Авилгатай тэмцэх газраас зөвшөөрөл авсаны үндсэн дээр томилж хэвшээд байна. Энэ онд нийт улс төрийн 6, төрийн үйлчилгээний 3 албан хаагчийн материалыг Авилгатай тэмцэх газарт хянуулж зөвшөөрөл авч томилсон. | | | |
| | | 10 | 3.1. Улс, аймаг, сумын баяр наадам, тэмдэглэлт ой, бүх нийтийн амралтын улирал эхэлж байгаатай холбогдуулан ой, хээрийн түймэр, хүн, малын гоц халдварт өвчин, зам тээврийн осол аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, бүх төрлийн гамшгийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн цогц арга хэмжээг мэргэжлийн байгууллагын удирдлага, зохицуулалт, иргэдийн идэвхтэй оролцоо, дэмжлэг, туслалцаатайгаар хэрэгжүүлэх | Тухайн тэмдэглэлт өдрүүдэд хариуцлагатай жижүүр гарган ажилласан байна. | Хэрэгжсэн | | |
| | | 11 | 3.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн өвс тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх, намрын ургац хураалтын бэлтгэлийг хангах, бусад аймаг, сумдаас ирэх отор нүүдлийг Засгийн газраас тогтоосон маршрутын дагуу мэргэжлийн байгууллагын хорио цээр, хяналт шалгалтын дор хэрэгжүүлэх, отроор өвөлжүүлэх, хаваржуулах ажлыг гэрээний үндсэн дээр зохион байгуулахад анхаарч ажиллах | Хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах тухай Аймгийн Засаг даргын 2025.09.03 -ны өдрийн А/553 дугаар захирамжийн хавсралтаар сумын аюулгүй нөөцөд өвс 122.4 тонн, тэжээл 106.1 тонн бэлтгэвэл зохих төлөвлөгөөний дагуу өвс 27,5 тонн, хивэг 8.7 тонн, овьёос 12,5 тонн, ногоон тэжээл 3 тонн үлдэгдэлтэй байсан. Нэмэлтээр 5 тонн өвс худалдан авч сумын аюулгүй нөөцийг бүрдүүлсэн. Энэ онд малчдын түвшинд бэлтгэсэн өвс, тэжээлийн нөөцийн мэдээг багийн дарга нараас албан тоот, хүснэгтийн дагуу авч сумын хэмжээнд нэгтгэн аймгийн ХХААГазарт 7 хоног бүр хүргүүлж байна. 2025 оны 10 сарын 13 -ний байдлаар өвс- 500 тн, ногоон тэжээл 250 тонн, гар тэжээл -350 тонн, давс, хужир, шүү 180 тонн | Хэрэгжсэн | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | бэлтгэвэл зохих төлөвлөгөөнөөс өвс 415 тонн, сүрэл 36 тонн, ногоон тэжээл 145 тонн, үйлдвэрийн тэжээл – 98 тонн, гар тэжээл -81 тонн, давс, хужир, шүү 37 тонн зэрэг бэлтгэсэн байна. Биелэлт: Нийт 1280 тонн хадлан бэлтгэхээс 826 тонныг биелэлттэй 64.5 хувьтай байна. | | | |
| | | 13 | 3.4. Өсвөр насны хүүхдүүдийн дунд гарч байгаа улаанбурхан өвчний дэгдэлтийг харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд бууруулах, хяналтад авах өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулах арга хэмжээг шуурхай зохион байгуулах | Сумын хэмжээнд энэ онд улаан бурхан өвчний дэгдэлт илрээгүй. | Хэрэгжээгүй. | | |
| | | 14 | 3.5. Хичээлийн шинэ жилийн бэлтгэл, сургууль, цэцэрлэгийн бэлэн байдлыг хангах, засварыг цаг тухайд нь хийж дуусгах, багшлах боловсон хүчний хангалтыг хэвийн болгох | 2024-2025 хичээлийн жилд урсгал засвар бүрэн хийгдсэн. Мэргэжлийн багшлах боловсон хангалт 90% | Хэрэгжсэн | | |
| | | 17 | 4.3. Түүх, соёлын дурсгалт газруудыг хамгаалах, аялал жуулчлалын үйлчилгээг хөгжүүлэх замаар орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах | Түүх соёлын үл хөдлөх дурсгалт газруудыг хайшжуулж хамгаалахаар шаарлагатай матералыг тооцоолон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажилд тусгуулсан. | Хэрэгжсэн | | |
| | | 18 | 4.4. Ажилтны мэдлэг, боловсролын түвшин мэргэжлийн ур чадварыг хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлэхэд байнга анхаарч, давтан сургах, мэргэшүүлэх, шинэ мэргэжил эзэмшүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх | Хэрэгжээгүй. | Хэрэгжээгүй | | |
| | | 19 | 4.5. Хөдөлмөр эрхлээгүй иргэд, албан бус хөдөлмөр эрхлэлтийг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн сүлжээнд хамруулах арга хэмжээ авч, хөдөлмөрийн статистикийн тогтолцоог бүрдүүлэх, | Хэрэгжээгүй. | Хэрэгжээгүй | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн чанарыг сайжруулж, ажиллах хүчний болон ажлын байрны судалгааг боловсронугй болгох ажлыг зохион байгуулах | | | | |
| | | 20 | 5. Энэ албан даалгаврын хэрэгжилт, үр дүнгийн талаарх мэдээллийг сар бүр Засгийн газрын Хэрэг газарт ирүүлж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, биелэлтэд нь хяналт тавьж явц үр дүнг нэгтгэн Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогтод тус тус үүрэг болгосугай. | Хэрэгжээгүй. | Хэрэгжээгүй | | |

| **Манай үнэлгээ** | **Тоо** | **Хувь** |
|---|---|---|
| Хэрэгжсэн | 137 | 91.95 |
| Хугацаа болоогүй | 7 | |
| Хэрэгжээгүй | 12 | 8.05 |
| | | |

ТАЙЛАН НЭГТГЭСЭН: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН

МЭРГЭЖИЛТЭН М.ХОРОЛГАРАВ

ХЯНАСАН: ЗДТГ-ЫН ДАРГА Б.БАТЦЭЦЭГ